





# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

*БНМАУ-ын Бага Хурлын Тамгын Газар*

№ 1

1991 оны нэгдүгээр сар

(1)

## ГАРЧИГ

### 1. БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ, БНМАУ-ЫН ХУУЛЬ

*Хуудасны дугаар*

1. Хууль батламжаах тухай № 12 . . . . .	4
2. БНМАУ-ын Албан татварын хууль . . . . .	5
3. Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль . . . . .	13
4. Хууль батламжаах тухай № 13 . . . . .	14
5. БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хууль . . . . .	15
6. Хууль батламжаах тухай № 1 . . . . .	30
7. БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай БНМАУ-ын хууль . . . . .	31
8. Хууль батламжаах тухай № 2 . . . . .	33
9. БНМАУ-ын Харилтын тухай хуулинд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хууль . . . . .	34
10. Хууль батламжаах тухай № 3 . . . . .	35
11. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тухай хууль . . . . .	36
12. Хууль батламжаах тухай № 4 . . . . .	44
13. БНМАУ-ын Бага Хурлын тухай хууль . . . . .	45
14. Хууль батламжаах тухай № 5 . . . . .	57
15. БНМАУ-ын Засгийн газрын тухай хууль . . . . .	58
16. Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хууль . . . . .	69
17. Хууль батламжаах тухай № 6 . . . . .	70

18. БНМАУ-ын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хууль	71
19. Хууль батламжаах тухай № 7	81
20. Олон улсын валютын сан, Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын санхүүгийн корпорац, Олон улсын хөгжлийн ассоциацид БНМАУ гишүүнээр элсэх тухай БНМАУ-ын хууль	82

## II. БНМАУ-ЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

21. Хороо байгуулах тухай № 34	84
22. Конвенцид нэгдэн орох тухай № 35	85
23. БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 36	85
24. БНМАУ-ын Эдийн засаг, нийгмийг 1991 онд хөгжүүлэх чиглэлийн тухай № 37	86
25. БНМАУ-ын Төсвийн 1989 оны гүйцэтгэлийн тайланг батлах тухай № 38	90
26. БНМАУ-ын Албан татварын хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 39	90
27. Сумын нэр өөрчлөх тухай № 40	92
28. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн тухай № 41	93
29. БНМАУ-ын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 42	94
30. Хуульчдыг дагаж мөрдөх журмын тухай № 1	95
31. Конвенц соёрхон батлах тухай № 2	95
32. Төрийн төв хэвлэлийн тухай № 4	96

## III. БНМАУ-ЫН ЕРӨНХИЙЛЭГЧИЙН ЗАРАЛГ

33. Цэрэнгийн Гүрбадамг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 50	98
34. Нямын Мишигдоржийг Элчин сайдаар томилох тухай № 51	98
35. Орон нутгийн Ардын Хурлын сонгууль явуулах тухай № 53	99
36. Цагдаагийн тэнгэрэг батлах тухай № 54	99
37. Төр, сүм хийдийн харилцааг зохицуулах тухай № 55	100
38. Комисс байгуулах тухай № 56	101
39. Ю. Марипаг Шударга журам медалиар шагнах тухай № 58	103

## IV. МОНГОЛЫН ПАРЛАМЕНТЫН БҮЛГЭМ

40. Монголын парламентын бүлэгийн дэргэн ажлын айлчлал	103
--	-----

## УНШИГЧ ТАНАА

«БНМАУ-ын хууль, зарлиг, тогтоолын амтгвал»-ийг зөвхөн албан ажлын хэрэгшээнд зориулан гаргаж байгаа нь ирээд төрийнхөө хуулийг тухай бүр нь уншиж, судлах, мөрдөж хэрэгжүүлэх өргөн бололцоо олохгүй байна. Энэ байдлыг харгалзан БНМАУ-ын Бага Хурал «Төрийн мэдээлэл»-ийг тогтмол гаргах нь зүйтэй гэж үзэж байна. БНМАУ-ын Бага Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлд «БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийн эхийг Улсын Бага Хурлын Тамгын газар өргөд, «Төрийн мэдээлэл» сэтгүүл болон «Ардын эрх» сонинд нийтлүүлэхээс задна төвхмөл болон халуулж болно. Эдгээрийг БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийн албан ёсны эх сурвалж болон хэрэглэнэ» гэж заасан юм.

«Төрийн мэдээлэл»-ийг бүх шатны Ардын хурал, тэдгээрийн байгууллагууд, зүйшээгтэй захиргаа, яам, улсын хороо, улс, хоршооллын болон нам, олон нийтийн байгууллагууд, хөдөлгөөн, үйлдвэр, аж ахуйн газар, хувьцаагаар хөдөлмөр эрхэлэгчид, ерд ирээдийн хэрэгшээнд зориулан Улсын Бага Хурлын Тамгын газар гаргаж байна. «Төрийн мэдээлэл»-д БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын тогтоол, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, батламж бичиг, БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Ерөнхийлөгч, Улсын Бага Хурлаас баталж гаргасан эрх зүйн бусад баримт бичиг, зэрэг хэлэлцээрийг үндсэн эхээр нь нийтэлж байх учир төрийн хууль тогтоомжийн албан ёсны эх сурвалж болно. Мөн БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хурал, БНМАУ-ын Ерөнхийлөгч, Монголын парламентын бүлэгийн албан ёсны бусад мэдээлүүд нийтлэгдэнэ. «Төрийн мэдээлэл»-д болон «Ардын эрх» сонинд нийтлэгдсэн хууль, зарлиг, тогтоолын албан ёсны анхны эхээс радио, телевиз, бусад сонин, сэтгүүл, хуулбарлан авч мэдээлж байх юм.

«Төрийн мэдээлэл»-ийн анхны дугаарт БНМАУ-ын Бага Хурлын II чуулганаар хэлэлцэн баталж, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн батлангилсан хууль, Улсын Бага Хурлын тогтоол, БНМАУ-ын ерөнхийлөгчийн зарлигууд, Монголын парламентын бүлэгийн төлч мэдээллийг нийтэлнэ.

«Төрийн мэдээлэл» нь албан газар, байгууллагууд, хоршоолал, ерд ирээдийн өдөр тутмын үйл ажиллагааны эрх зүйн талын аялга, дотнын туслах, авчлаач болно гэдэгт найлаж байна.

«Төрийн мэдээлэл»-ийн таларх та бүхнээс ирүүлсэн саналыг Улсын Бага Хурлын Тамгын газар тухайн үеэр цаашдын ажилдаа анхааран үзэж байх болно.

УЛСЫН БАГА ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1990 оны 12 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
шот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Албан татварын хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай БНМАУ-ын хуулийг тус тус зөвшөөрөн батламжласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БНМАУ-ЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Нийтлэл үндэслэл*

*1 дүгээр зүйл.* БНМАУ-ын Албан татварын хуулийн зорилт

Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төвлөрсөн сан-БНМАУ-ын төсвийг бүрдүүлэхэд өмчийн бүх төрөлд хамаарагдах үйлдвэрийн газар, байгууллага болон хүн амаас өрх тэгш, шударгаар оролцох нийгмийн үүргийг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршино.

*2 дугаар зүйл.* БНМАУ-д албан татварын харилцааг зохицуулах хууль тогтоомж

БНМАУ-ын төсөвт албан татвар (цаашид «татвар» гэх) төлөхтэй холбогдсон харилцааг БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан БНМАУ-ын хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

*3 дугаар зүйл.* Албан татварын төрөл

БНМАУ-ын татвар шууд ба шууд бус татвараас бүрдэнэ.

Шууд татварт үйлдвэрийн газар, байгууллага болон хүн амын нөхгөн орлого, хөрөнгөд оногдуулах татвар; шууд бус татварт гүйлгээний татвар, газар, байгалийн нөөц ашигласны төлбөр хамаарна.

Татварыг бэлэн ба бэлэн бус тооцоогоор төлнө.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Хүн амын орлогод оногдуулах албан татвар*

*4 дүгээр зүйл.* Албан татвар төлөгч

БНМАУ-ын иргэд, БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаадын харьяат (БНМАУ-ын хууль, БНМАУ-ын олон улсын

гэрээнд өөрөөр заагаагүй бол), харьяалалгүй хүмүүс татвар төлөгч байна.

*5 дугаар зүйл.* Албан татвар оногдуулах орлого, хөрөнгө

Дор дурдсан орлого, хөрөнгөд татвар оногдуулна:

- 1) үндсэн ба нэмэгдэл цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах (цалин, хөдөлмөрийн хөлсөнд тооцсон) биет зүйлсийн орлого, гэрээ түрээсээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсний орлого, үйлдвэрлэл, ажлын үр дүнгийн шагнал, тэтгэвэр, тэтгэмжийн орлого;
- 2) үндсэн ажлаасаа гадуур үйлдвэр, байгууллага, иргэдэд ажил, үйлчилгээ гүйцэтгэсний орлого;
- 3) үйлдвэрийн газар, байгууллага татан буутдсанаас оногдох хувь хөрөнгө;
- 4) хувинараа ажил үйлчилгээ эрхэлсний орлого;
- 5) зохиогчийн шагналын орлого;
- 6) гадаад валютын орлого;
- 7) гэрээслэлээр өв залгамжилсан мөнгө, биет зүйлсийн орлого;
- 8) хувийн мал, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн борлуулсны орлого;
- 9) энэхүү хуулийн 9 дүгээр зүйлд татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого.

*6 дугаар зүйл.* Албан татварын хувь, хэмжээ

1. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1, 6-д заасан орлогын сарын нийлбэр дүнд дор дурдсан хувь, хэмжээгээр татвар оногдуулна:

Сарын орлогын хэмжээ (төгрөгөөр)	Татварын хувь, хэмжээ
501—700	6 төгрөг 33 мөнгө дээр 500 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 2,4 хувиар нэмнэ
701—900	11 төгрөг 13 мөнгө дээр 700 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 2,6 хувиар нэмнэ
901—1200	16 төгрөг 33 мөнгө дээр 900 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 2,7 хувиар нэмнэ
1201—1500	24 төгрөг 43 мөнгө дээр 1200 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 2,9 хувиар нэмнэ
1501—2000	33 төгрөг 13 мөнгө дээр 1500 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 3,5 хувиар нэмнэ
2001—2500	50 төгрөг 63 мөнгө дээр 2000 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 5,0 хувиар нэмнэ
2501—3000	75 төгрөг 63 мөнгө дээр 2500 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 10,0 хувиар нэмнэ
3001—4000	125 төгрөг 63 мөнгө дээр 3000 төгрөгснөөс дээш орлогын дүнгээс 20,0 хувиар нэмнэ

400 1—5000	325 төгрөг 63 мөнгө дээр 4000 төгрөгнөөс дээш орлогын дүнгээс 30,0 хувиар нэмнэ
500 1—6000	625 төгрөг 63 мөнгө дээр 5000 төгрөгнөөс дээш орлогын дүнгээс 40,0 хувиар нэмнэ
600 1, түүнээс дээш	1025 төгрөг 63 мөнгө дээр 6000 төгрөгнөөс дээш орлогын дүнгээс 50,0 хувиар нэмнэ

**ТАГЛАВАР:** Сарын орлогод оногдуулах татварын хувь, хэмжээ нь нийт орлогын 46 хувиас хэтрэхгүй.

2. Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 2—5; 7—9-д заасан 500 хүртэл төгрөгийн орлогод 1,25 хувиар, 501 төгрөгнөөс дээш орлогод энэ зүйлийн 1-д заасан хувь, хэмжээгээр татвар оногдуулана.

Шинэжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн 1500 хүртэл төгрөгийн шагналын орлогод энэ зүйлийн 2-д заасан хувь хэмжээгээр, 30000 хүртэл төгрөгийн шагналын орлогод 3 хувиар, 30001, түүнээс дээш 5 хувиар татвар оногдуулна.

7 дугаар зүйл. Гэрээгээр буюу хувиараа ажил, үйлчилгээ гүйцэтгэсний орлого

Үйлдвэрийн газар, байгууллагад гэр бүлээрээ буюу хамт олноороо гэрээлэн гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ, түүнчлэн иргэний хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ажил гүйцэтгэсэн иргэдийн орлогыг гэрээнд оролцогчдод болон ажилласан сарын тоонд хувааж нэг хүний сарын орлогын хэмжээг тодорхойлож энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1-д заасан хувь, хэмжээгээр татвар оногдуулж, татварын эцсийн тооцоог гэрээ дүгнэх үед хийнэ.

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээг хувиараа эрхлэгчид татвар оногдуулах журмыг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл. Гадаадад ажиллаж байгаа БНМАУ-ын иргэдийн орлогод албан татвар оногдуулах

БНМАУ-аас гадаад оронд ажиллаж байгаа тус улсаас цаали авдаг БНМАУ-ын иргэдийн орлогод татвар оногдуулах асуудлыг БНМАУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Албан татвараас чөлөөлөх орлого

Дор дурдсан орлогыг татвараас чөлөөлнө:

1) 500 хүртэл төгрөгийн сарын үндсэн ба нэмэгдэл цаали, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах (цаали, хөдөлмөрийн хөлсэнд тооцсон) биет зүйлсийн орлого, гэрээ, түрээсээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсний орлого, тэтгэвэр тэтгэмж;



2) хөдөлмөрийн чадвар алдалтын I зэрэг болон жаргаагүй, дүлийгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын II зэрэгт орсон иргэдийн хөдөлмөрийн хөлс, орлого;

3) хөдөлмөрийн чадвар түр алдалт, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээс бусад тэтгэмж, хүүхдийн тэтгэлгийн орлого;

4) үйлдвэрлэл, ажлын үр дүнгийн шагналаас бусад бүх төрлийн нэг удаагийн шагналын орлого;

5) хувийн аж ахуйгаас улс, орон нутгийн төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлсэн бүтээгдэхүүний орлого;

6) иргэдээс ажил, үйлдвэрлэлийн үүргээ биелүүлж яваад бэртэх буюу эрүүл мэнд нь гэмтсэний улмаас учирсан хохирлыг нөхсөн орлого;

7) даатгалын байгууллагаас иргэдэд учирсан хохирлыг нөхсөн орлого;

8) улсын зээллэг болон хонжворт сугалааны орлого, зээлээр авсан мөнгө;

9) бэлэглэсэн мөнгө, биет зүйлсийн орлого;

10) томилолтоор ажиллах хугацааны зам хоногийн зардал олгосон мөнгө;

11) улс, нийгмийн ач холбогдолтой энэрэнгүй үйлсийн сан хөмрөгт хандивласан мөнгө, биет зүйлсийн орлого.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Үйлдвэрийн газар, байгууллагын орлогоос  
хураах албан татвар*

*10 дугаар зүйл. Албан татвар төлөгч*

Өмчийн бүх төрөлд хамаарагдах үйлдвэрийн газар, байгууллага татвар төлөгч байна.

*11 дүгээр зүйл. Албан татвар оногдуулах орлого*

1. Татвар төлөгчийн болон ажил, үйлчилгээний орлогоос түүхий эд, үндсэн ба туслах материал, хагас боловсруулсан зүйл, уур ус, эрчим хүч, түлш шатахуун, сав баглаа боодол, салбит хэрэгслийн зардал, тээврийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал, нийгмийн даатгалын шимтгэл, газар, байгалийн нөөц ашигласны төлбөрийг хассан орлогод орлогын татвар оногдуулна.

2. Спирт, архи, дарс, тамхи болон алт, мөнгө, үнэт металл, эрдэнийн чулуун эдлэлийн борлуулалтын орлогод гүйлгээний татварыг оногдуулна.

*12 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ*

1. Үйлдвэрийн газар, байгууллагын жилийн орлогод дор дурдсан хувь, хэмжээгээр орлогын татварыг оногдуулна:

Жилийн орлогын хэмжээ (төгрөгөөр)	Татварын хувь, хэмжээ
0—1000000	8,0 хувь
1000000 II—5000000	30,0 мянган төгрөг дээр 1 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 15 хувийг нэмнэ
5000000 II—10000000	680,0 мянган төгрөг дээр 5 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 22 хувийг нэмнэ
10000000 II—20000000	1780,0 мянган төгрөг дээр 10 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 30 хувийг нэмнэ
20000000 II—30000000	4780,0 мянган төгрөг дээр 20 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 38 хувийг нэмнэ
30000000 II-ээс дээш	8580,0 мянган төгрөг дээр 30 сая төгрөгөөс дээш орлогын дүнгийн 46 хувийг нэмнэ

**ТАГААБАР:** Төрийн өмчийг эзэмшигч үйлдвэрийн газар, байгууллагуудын эдийн засгийн адил нөхцөл, тэнцвэртэй хөгжлийг хангах үүднээс тэдгээрийн орлогод оногдуулах татварыг дээр зэвсэг хэмжээн дээр 20 хүртэл нэгжээр нэмэгдүүлэн зохицуулах эрхийг БНМАУ-ын Засгийн газар эдэлнэ.

2. Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газрын орлогод дээрхи хувь, хэмжээгээр татвар оногдуулах боловч татварын хэмжээ ашгийн нь 40 хувиас хэтрэхгүй.

3. Гүйлгээний татвар болон газар, байгалийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

*13 дугаар зүйл. Албан татварыг хөнгөлөх*

1. Татвар төлөгчийн татвар оногдуулбал зохих орлогыг дор дурдсан хувь, хэмжээгээр хоронгдуулна:

1) өндөр үр ашиг бүхий шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дэвшилтэт тэсвэр техналоги зохион бүтээх, турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мэргэжилтэн баалгах арга хэмжээнд тухайн жилд зарцуулсан өөрийн хөрөнгийн хэмжээ, түүнчлэн энэ зорилгатаар аяч ашигласан банкны урт хугацаат зээлийн төлбөрийн 60 хүртэл хувиар;

2) байгалийн тэнцлийг хангах арга хэмжээнд зарцуулсан хөрөнгийн хэмжээгээр;

3) улс, нийгмийн чанартай энэрэнгүй үйлсийн сан хөврөгт зориулан татвар төлөгчөөс хандивласан хөрөнгөөр.

2. Татварын хэмжээг дор дурдсан хувиар бууруулж болно:

1) хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн байгууллаагчийн орлогод оногдуулах татварыг 60 хүртэл хувиар;

2) хүнсний үйлдвэрийн мах, сүү, гурил, талхны үйлдвэрлэлийн орлогод оногдуулах татварыг 60 хүртэл хувиар;

3) тахир дутуу иргэд ажилладаг үйлдвэрийн газар, байгууллаагчийн татварын хэмжээг түүний нийт ажилчдад тахир дутуу иргэдийн эзэлдэг хувиар;

4) БНМАУ-ын хууль тогтоомжоор жинхэнэ үйлдвэрт хамрагдах үйлдвэрийн газрын татварыг үйлдвэрлэл, үйлчилгээгээ явуулж эхэлснээс хойш 2 жилийн хугацаанд 50 хүртэл хувиар.

3. Энэ зүйлд заасан татварын хөнгөлөлт үзүүлэх эрхийг БНМАУ-ын Сангийн яам, орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа эдэлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Албан татвар төлөх*

#### *14 дүгээр зүйл. Албан татвар төлөх журам*

Үйлдвэрийн газар, байгууллага болон хүн эмнэл орлогод оногдуулсан татварыг тухайн байгууллага сард 2-оос доошгүй удаа харилцагч төсөвт төлж, тайлан гаргана.

Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрийн газрын орлого (ашиг) болон улсын үйлдвэрийн газар, байгууллаагчийн орлогод оногдуулах татварыг улс, орон нутгийн төсвийн хооронд хуваарилах асуудлыг БНМАУ-ын Засгийн газар шийдвэрлэнэ.

Хувиараа хөдөлмөр эрхлэгч, тогтмол бус нэмэгдэл орлоготой иргэд орлогодоо оногдох татварыг улирал бүр орон нутгийн төсөвт төлж, татварын жилийн тооцоог орлого татвар тодорхойлох хуудсаар хийнэ.

#### *15 дугаар зүйл. Албан татвар төлөгчийн эрх, үүрэг*

1. Татвар төлөгч дор дурдсан эрхтэй:

1) энэ хуулиар олгосон татварын хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх;

2) татварыг үндэслэлгүй оногдуулсан гэж үзвэл захиргааны болон шүүхийн журмаар гомдол гаргах.

Гомдол гаргах нь оногдуулсан татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй. Уг гомдлыг хянаж байгаа шүүхийн шийдвэрээр татвар төлөхийг түр зогсоож болно.

2. Татвар төлөгч дор дурдсан үүрэгтэй:

1) үйлдвэрийн газар, байгууллага ирэх төсвийн жилд улс орон нутгийн төсөвт төлөх татварын умрал, сэрми хуваарийг харилцагч санхүүгийн байгууллагад төсвийн жил дуусахаас 2 сарын өмнө, хувиараа хөдөлмөр эрхлэгч, орон нутгийн төсөвт төлөх татварын тооцог орлого татвар тодорхойлох хуудсаар харилцагч санхүүгийн байгууллагад төсвийн жил өхөлснөөс хойш 21 хоногийн дотор тус тус ирүүлэх;

2) өөрийн орлогоо үнэн зөв тодорхойлж татварыг тогтоосон хугацаанд нь төлж, тайланг санхүүгийн байгууллагад ирүүлэх;

3) татварын хөнгөлөлтийн үндэслэл, тооцог тухай бүр үнэн зөв хийж харилцагч санхүүгийн байгууллагад хүргүүлэх;

4) татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар шуурхай арга хэмжээ авах.

16 дугаар зүйл. Албан татварын хяналт

Татварын хяналтыг БНМАУ-ын Сангийн яам (татварын улсын алба), орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа хэрэгжүүлнэ.

Татварын улсын албаны дүрмийг БНМАУ-ын Засгийн газар батална.

17 дугаар зүйл. Албан татвар төлөгчид хүлээлгэх харилцаа

Татварын улсын алба албан татварын хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд дор дурдсан харилцаага хүлээлгэнэ:

1) татвар оногдуулах орлогыг санаатайгаар бууруулсан буюу нуун дарагдуулсан бол уг орлогод оногдох татварыг нөхөн төлүүлж, түүнтэй тэнцэх хэмжээний торгууль оногдуулна;

2) хугацаа хожимдуулсан хонго тутамд дутуу төлсөн татварын дүнгээс 1 хувийн торгууль (алданги) оногдуулна;

3) БНМАУ-ын хууль тогтоомжоор хувиараа эрхлэхийг хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан татвар төлөгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал уг үйл ажиллагааг эрхлэж олсон орлого болон үйлдвэрлэл, үйлчилгээний багаж хэрэгслийг нь хурааж 700—1000 төгрөгөөр торгоно;

4) БНМАУ-ын хууль тогтоомжинд хориглоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг зохих зөвшөөрөлгүй явуулсан татвар төлөгчийг уг үйл ажиллагаа эрхлэж олсон орлогыг нь хурааж, 500—800 төгрөгөөр торгоно;

5) татвар болон торгууль төлөхөөс зайлсхийсэн гэм буруутай этгээдийг 500—1000 төгрөгөөр торгоно,

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1990 оны 12 дугаар  
сарын 7-ны өдөр

Улаанбаатар  
хот

— 1 —  
БҮГД НАПРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ

1990 оны 12 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮҮИ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Албан татварын хууль батлагдсантай холбогдуулан 1959 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Мал бүхий иргэддээс хураах мал аж ахуйн татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
парийн бичгийн дарга

Б. ЧИМИД

— 14 —

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1990 оны 12 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУУЛЬ

1990 оны 12 дугаар  
сарын 6-ны өдөр

Улаанбаатар  
хот

## БНМАУ-ЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Иргэний хуулийн 1-р зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

*«1-р зүйл. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хуулийн зорилт*

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль нь иргэдийн эдийн болон оюуны хэрэгцээг аль болох бүрэн дүүрэн хангах зорилгоор эд хөрөнгийн болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус амины харилцаа, түүнчлэн хуульд заасан бол эд хөрөнгөнийхтэй холбоогүй эд хөрөнгийн бус амины бусад харилцааг зохицуулна.»

2. БНМАУ-ын Иргэний хуулийн «Өмчийн эрх» гэсэн II хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### «II ХЭСЭГ ӨМЧИЙН ЭРХ ЗҮП

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Нийтлэг үндэслэл*

*59-р зүйл. БНМАУ дахь өмч*

БНМАУ-д хувийн, нийтийн өмч байна. Өмчийн холимог хэлбэр байж болно.

Төрөөс өмчийн бүх төрөл, хэлбэр чөлөөтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлж, тэдгээрийн халдашгүй байдлыг хуулиар хамгаална.



60-р зүйл. Өмчлөгч

БНМАУ-д төр, иргэд, тэдний хоршоолол, олон шийт болон шашин байгууллага өмчлөгч байна. Мөн гадаад улс, түүний иргэн, байгууллага, түүнчлэн олон улсын байгууллага, харьяалалгүй хүмүүс БНМАУ-ын хууль, БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол БНМАУ-д өмчлөгч байж болно.

61-р зүйл. Өмчлөлийн зүйлс

Эзэмшигч байж болох эд юмс, оюуны үнэт зүйлсийг өмчилж болно.

62-р зүйл. Үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө

Өмчлөлийн зүйл болох эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гэж ялгагдана. Үл хөдлөх эд хөрөнгөд газар, барилга байгууламж хамаарагдана.

Үл хөдлөх эд хөрөнгийг төрийн эрх бүхий байгууллага бүртгэнэ.

Үл хөдлөхөөс бусад эд хөрөнгө нь хөдлөх эд хөрөнгө байна.

63-р зүйл. Өмчлөх эрх

Өмчлөгч нь өмчлөлийн зүйлсээ хуулийн хүрээнд бүрэн мэдэж эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

Өмчлөгч нь өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ бусад өмчлөгчдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх үүрэгтэй.

Газар, түүний хэвлэл, байгалийн нөөцийг өмчлөх эрх нь БНМАУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхэд байна.

64-р зүйл. Өмчлөгч биш этгээдийн эрх

Өмчлөгч биш этгээд нь эд хөрөнгө, оюуны үнэт зүйлсийг хууль буюу гэрээнд нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

65-р зүйл. Эд хөрөнгийг дундаа өмчлөх

Хоёр буюу түүнээс дээш этгээд эд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болно. Эдгээр этгээд тус бүр өмчлөх эрхээ бие даан хамгаалуулах эрхтэй.

Эд хөрөнгийг дундаа өмчлөгчдийн хариуцаал зохих үүргийн талаар гаргуулах төлбөрийг тухайн өмчлөгчид оногдох эд хөрөнгөөс гаргуулна.

Эд хөрөнгийг дундаа өмчлөхтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

66-р зүйл. Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх

Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгийг өмчлөгчдийн хэлцлийн

дагуу эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна. Үүнтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчилж байгаа өмчлөгч бүр оногдох хэсгээ бусдын өмчлөлд шилжүүлэх буюу өөр байдлаар захиран зарцуулах эрхтэй.

*67-р зүйл.* Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгээ худалдах, түрээсээр өгөх

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчдийн аль нэг нь өөртөө оногдох хэсгээ худалдах, түрээслэн өгөх тохиолдолд энэ тухайгаа бусаддаа мэдэгдэх үүрэгтэй бөгөөд тэдгээр нь уул хэсгийг тэргүүн ээлжинд худалдаж авах, түрээслэх эрхтэй. Хэрэв тэд нийхүү худалдах, түрээсээр өгөх тухай мэдэгдсэн өдрөөс хойш нэг сарын дотор хариу өгөөгүй бол тухайн өмчлөгч оногдсон хэсгээ өөр этгээдэд худалдах, түрээсээр өгөх эрхтэй.

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчдийн аль нэг нь энэ зүйлийн нэг дэх ангид заасныг зөрчиж дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгөөс өөртөө оногдох хэсгээ худалдсан буюу түрээсээр өгсөн бол бусад өмчлөгчид нь худалдан авагч, түрээслэгчийн эрх, үүргийг өөртөө шилжүүлж авахыг шаардаж зургаан сарын дотор шүүхэд нэхэмжлээ гаргаж болно.

*68-р зүйл.* Дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгээ салгах

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчид нь уул эд хөрөнгөөс өөртөө оногдох хэсгийг салган авахыг шаардах эрхтэй. Дундаа хэсгээр өмчилж байгаа эд хөрөнгөөс өөртөө оногдох хэсгийг салгаж авах талаар бусадтайгаа харилцан тохиролцоогүй бөгөөд оногдох хэсгийг нийхүү салгахад уул эд хөрөнгийн аж ахуйн зориулалт алдагдахгүй бол тухайн өмчлөгчийн хүсэлтээр эд хөрөнгөөс түүнд оногдох хэсгийг шүүх салгаж өгнө. Харин салгах боломжгүй бол оногдох хэсгийнх нь үнийг өмчлөгчид олгуулахаар шийдвэрлэж болно.

*69-р зүйл.* Дундаа хэсгээр өмчилж буй эд хөрөнгийн талаар гарсан зардлыг хуваарилах

Эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгчид нь дундын эд хөрөнгөд оногдох татвар, төлбөр, мөн эд хөрөнгийг арчилж хамгаалахад гарсан зардал, уг өмчийн харилцаанаас үүссэн үүрэгтэй холбоотой бусад зардлыг өөртөө оногдох хэсгийн хэмжээгээр хариуцна.

*70-р зүйл.* Эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх

Өрхийн гишүүд нь өрхийнхөө эд хөрөнгийг дундаа хамтран өмчилнө.

Эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх өөр хэлбэрийг БНМАУ-ын хуулиар тогтоож болно.

Өрхийн эд хөрөнгөтэй холбогдсон үүргийг уул өрхийн эд хөрөнгөөр харууцна.

*71-р зүйл.* Өрхийн эд хөрөнгөөс өрхийн гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох

Өрхийн эд хөрөнгөөс түүний гишүүдэд оногдох хэсгийг дор дурдсан үед тодорхойлно:

- 1) өрхийн гишүүн өрхийн бүрэлдэхүүнээс гарах;
- 2) өрхийн гишүүний гүйцэтгэх үүргийн талаар төлбөр гаргуулах;
- 3) өрхийн гишүүн өрх тусгаарлах.

*72-р зүйл.* Өрхийн гишүүнд оногдох эд хөрөнгийн хэмжээг тодорхойлох

Өрхийн нэг гишүүнд оногдох эд хөрөнгийн хэмжээг тогтоохдоо насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнийг оролцуулан нийтэд адил хэмжээгээр тогтооно. Өрхийн гишүүний аль нэгний эрх ашгийг харгалзан шүүх өөрөөр тогтоож болно.

*73-р зүйл.* Өрхийн гишүүн өрхийн бүрэлдэхүүнээс гарах

Өрхийн нэг буюу хэд хэдэн гишүүн өрх тусгаарлахгүйгээр уул өрхийн бүрэлдэхүүнээс гарвал дундын эд хөрөнгөөс оногдох хэсгээ авах боловч үлдэж байгаа өрхийн аж ахуйг цаашид явуулахад зайлшгүй шаардагдах хэрэгслийг авч болохгүй.

Оногдох хэсгийг эд хөрөнгөөр өгөх боломжгүй бол үнийг мөнгөөр нь төлнө.

Дундын хөрөнгөөс оногдох хэсгийн хэмжээг хуваах талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

*74-р зүйл.* Өрхийн эд хөрөнгөөс хувь таслах, өрх салгахыг шаардах

Өрхийн эд хөрөнгөөс хувь таслах, өрх салгахыг шаардах эрхийг уг өрхийн насанд хүрсэн гишүүн эдэлнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох*

*75-р зүйл.* Гэрээний дагуу олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх үүсэх

Гэрээний дагуу олж авсан эд хөрөнгийг өмчлөх эрх (өмчлөгч биш байгууллагын хувьд энэ хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх) нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол уул эд хөрөнгийг шилжүүлсэн үеэс эхлэн үүснэ. Эд хөрөнгийг шилжүүлэх гэрээ нь хуульд зааснаар зохих байгууллагаар батлуулан гэрчлүүлэх ёстой бол нийнхүү батлуулан гэрчлүүлсэн үеэс эхлэн уул эд хөрөнгийг өмчлөх эрх үүснэ.

*76-р зүйл. Эд хөрөнгийг шилжүүлсэнд тооцох*

Эд хөрөнгийг дор дурдсан тохиолдолд шилжүүлсэнд тооцно:

- 1) эд хөрөнгийг олж авч байгаа этгээдэд гардуулан өгсөн;
- 2) эд хөрөнгийг хүргэж өгөх үүрэг хүлээгээгүй бол эд хөрөнгийг олж авч байгаа этгээдэд хүргэж өгөх үүрэг хүлээсэн бусад этгээдэд хүлээлгэж өгсөн;
- 3) эд хөрөнгийг өгч авалцах тухай дагалдах бичиг баримтыг хүлээлгэн өгсөн.

*77-р зүйл. Газар өмчлөх эрх үүсэх*

Газрыг өмчлөх эрх нь газар авч байгаа этгээдэд уг газрыг хүлээлгэн өгч, зохих бичиг баримтад гарын үсэг зурсан үеэс эхлэн үүснэ.

Газрыг өмчлөх эрх нь түүний хэвийн ба байгалийн нөөцөд хамаарахгүй.

*78-р зүйл. Үр төл, орлогыг өмчлөх эрх*

Хуульд буюу өмчлөгчөөс бусад этгээдтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгөөс олж байгаа орлого, мал, тэжээлэр амьтны үр төл нь уул эд хөрөнгө, мал, тэжээлэр амьтан өмчлөгчийн өмчид байна.

*79-р зүйл. Барилга байгууламж, орон сууцны байшин, хашааг өмчлөх эрх шилжихэд тэдгээрийн дэвсгэр газрыг эдлэх эрх шилжих*

Төрийн өмчийн газар дээрх барилга байгууламж, орон сууцны байшин, хашааг өмчлөх эрх шилжихэд тэдгээрийн дэвсгэр газрыг эзэмших, ашиглах эрх нэг адил шилжинэ.

Барилга байгууламж, орон сууцны байшин, хашааг буулгаж авах явдал нь үүнд хамаарахгүй.

*80-р зүйл. Эзэнгүй эд хөрөнгө*

Эзэнгүй буюу эзэн нь мэдэгдэхгүй эд хөрөнгийг орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа бүртгэн зохих хамгаалалтад авна.

Хэрэв бүртгэн авч нийтэд мэдээлснээс хойш зургаан сарын дотор эзэн нь илрэхгүй бол тухайн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа уул эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлнэ.

*81-р зүйл. Гээгдэл эд хөрөнгө*

Гээгдсэн эд хөрөнгийг олсон этгээд эзэнд нь даруй мэдэгдэж буцаан өгөх буюу эзэн нь мэдэгдэхгүй бол орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд өгнө.

Үйлдвэрийн газар, байгууллага, нийтийн тээврийн хэрэгслээс олдсон эд хөрөнгийг тухайн үйлдвэрийн газар, байгууллагын захиргаанд өгнө. Гээгдсэн эд хөрөнгийн талаар нийтэд мэдээлснээс хойш нэг сарын дотор эзэн нь илрэхгүй бол үйлдвэрийн газар, байгууллагын захиргаа олдсон эд хөрөнгийг орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд шилжүүлнэ. Хэрэв олдсон эд хөрөнгийн эзэн нь нэг жилийн дотор илрэхгүй бол цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа уул эд хөрөнгийг төрийн өмчид шилжүүлнэ.

Гээгдсэн эд хөрөнгийг олж эзэнд нь өгсөн хүн уг эзлээс, хэрэв төрийн өмчид шилжүүлсэн бол төрийн зохих байгууллагаас уул зүйлийн үнийн хорь хүртэл хувьтай тэнцэх шагнал авах эрхтэй.

*82-р зүйл. Алдуул мал*

Алдуул мал барьсан этгээд малын эзэн мэдэгдэж байвал уул эзэнд нь даруй мэдэгдэж буцаан өгөх, эсхүл сарын дотор орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд мэдэгдэх үүрэгтэй.

Орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа малын эзнийг олох, эзнийг олтод нь уул малыг боломжоотой байгууллага буюу иргэнд шилжүүлж маллуулах арга хэмжээ авна.

Алдуул малын талаар нийтэд мэдээлснээс хойш нэг жилийн дотор эзэн нь илэрвэл малыг төлийн хамт буцааж өгнө. Хэрэв дурдсан хугацаанд эзэн нь илрэхгүй бол цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа уул малыг төрийн өмчид шилжүүлнэ.

Алдуул мал барьж эзэнд нь өгсөн хүн гаргасан зардлаа уул эзлээс, хэрэв төрийн өмчид шилжүүлсэн бол төрийн зохих байгууллагаас төлүүлж авахаас гадна малын үнийн хорь хүртэл хувьтай тэнцэх шагнал авах эрхтэй.

*83-р зүйл. Дарагдмал үнэт зүйл.*

Газарт булсан, бусад аргаар нууж орхисон бөгөөд эзэн нь

мэдэгдэхгүй байгаа дарагдмал мөнгө, үнэт зүйл төрийн өмч болно. Дарагдмал мөнгө, үнэт зүйлийг илрүүлсэн хүн энэ тухай орон нутгийн цагдаагийн газар буюу Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд даруй мэдэгдэж шилжүүлэн өгөх үүрэгтэй.

Дарагдмал үнэт зүйлийг илрүүлж зохих байгууллагад шилжүүлсэн хүн төрийн зохих байгууллагаас уул зүйлийн үнийн хорь хүртэл хувьтай тэнцэх шагнал авах эрхтэй.

Албан үүргийн ёсоор хайгуул, малталт хийж байгаад дарагдмал үнэт зүйлийг илрүүлбал энэ хуульд заасан шагнал олгохгүй.

*84-р зүйл.* Түүх, соёлын дурсгалт зүйлд хайр гэмгүй хандах

Хэрэв өмчлөгч өөртөө байгаа бөгөөд улсын бүртгэлд авагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэж гэмтээх зэргээр хайр гэмгүй эзэмшвэл орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, төрийн зохих байгууллагаас уул этгээдэд урьдчилан сануулж дээрх байдлаа засахыг хугацаа тогтоон шаардана.

Ийнхүү сануулж тогтоосон хугацаанд уул байдлаа зогсоохгүй бол төрийн зохих байгууллагын нэхэмжлэлээр дээрх эд хөрөнгийг шүүх хураан авч төрийн өмчид шилжүүлнэ.

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хайр гэмгүй эзэмшиж байгаа учраас түүнийг хураан авах явдал нийтийн ашиг сонгохлын үүднээс зайлшгүй шаардлагатай байвал төрийн зохих байгууллага нь урьдчилан сануулахгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Энэ зүйлд зааснаар эд хөрөнгийг хураан авахдаа харну төлбөр төлөх эсэхийг шүүх шийднэ.

*85-р зүйл.* Бусдын эд хөрөнгийг засан сайжруулах буюу дахин боловсруулах

Хууль буюу гэрээний дагуу бусдын эд хөрөнгийг засан сайжруулах буюу дахин боловсруулах замаар шинэ зүйл бий болгох, зориулалтыг нь өөрчилсөн тохиолдолд өмчлөгчийн саналыг үндэслэн уул эд хөрөнгийн үнийг төлж өөртөө авах, эсхүл засан сайжруулах, дахин боловсруулахад гаргасан зардаа авч уул эд хөрөнгийг өмчлөгчид буцаан өгнө.

*86-р зүйл.* Эд хөрөнгө нийлэх буюу холилох

Хэд хэдэн өмчлөгчийн мэдэлд байсан эд хөрөнгө нийлэх буюу холилдсоноос түүнийг салгаж авах боломжгүй болох буюу салгаж авсны үр дүнд уул эд юмсад ихээхэн хохирол учрахаар байвал уул эд хөрөнгийг дундаа хамтран өмчилнө.

Хэрэв аль нэгэн өмчлөгч дундаа өмчлөхийг хүсэхгүй бол эд хөрөнгө нийлэхээс өмнө хамгийн их хэсгийг нь өмчилж байсан этгээд бусаддаа үнийг төлж уул зүйлийг авах, эсхүл өөрийн хэсгийн үнийг авч эд хөрөнгийг бусдад шилжүүлэх эрхтэй.

87-р зүйл. Дуудлагын худалдаагаар өмчлөх эрхийг олж авах

Дуудлагын худалдаагаар эд хөрөнгө худалдаж авахад уул эд хөрөнгийн өмчлөгч нь хэн байснаас хамаарахгүйгээр худалдан авагч этгээдэд өмчлөх эрх үүснэ.

88-р зүйл. Гэрээ ёсоор өмчийн эрх шилжих үед эд хөрөнгө гэнэтнийн аюулаас устах буюу гэмтэх

Эд хөрөнгө шилжихээс өмнө гэрээ ёсоор өмчлөх эрх шилжсэн байтал эд хөрөнгө гэнэтнийн аюулаас болж (аль ч талын буруугүйгээр) устсан буюу гэмтсэн бөгөөд гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол өмчлөгч хариуцна.

Эд хөрөнгө шилжүүлэх хугацааг хожимдуулсан, эсхүл хүлээн авах хугацааг хожимдуулсан бол гэнэтнийн аюулаас болж учирсан хохирлыг хугацаа хожимдуулсан этгээд хариуцна.

Эд хөрөнгийг энэ хуулийн 64-р зүйлд заасны дагуу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх бүхий өмчлөгч биш этгээдэд эд хөрөнгө гэрээгээр шилжүүлэхэд энэ журмыг нэгэн адил хэрэглэнэ.

89-р зүйл. Тусгай зөвшөөрөлтэйгээр олж авах зүйл

Ангийн буунаас бусад гаал зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл, мансууруулах бодис, хүчтэй нөлөөлөх хор зэрэг улс, иргэдийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хяналт тавих шаардлагатай эд юмсыг гагцхүү тусгай зөвшөөрөлтэй олж авна. Тусгай зөвшөөрөлтэй олж авах зүйлийн жагсаалт, зөвшөөрлийн журмыг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

90-р зүйл. Эд хөрөнгийг дайчлан гаргуулах, хураан авах

Улс, нийтийн ашиг сонирхлын үүднээс бусдын эд хөрөнгийн үнийг төлж төрийн өмчид дайчлан гаргуулах, мөн эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг шийтгэл болгон үнэ төлбөргүй хураан авах явдлыг гагцхүү БНМАУ-ын хуульд заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ.

91-р зүйл. Эд хөрөнгийг өмчлөлийн нэг төрөл хэлбэрээс нөгөөд шилжүүлэх

Хуулийн дагуу буюу гэрээгээр өмчлөлийн аливаа төрөл, хэлбэрийг өөрчилж өмчлөх эрхийг олж авч болно.

Төрийн өмчийн эд хөрөнгийг бусад өмчлөгчид шилжүүлэх нөхцөл журмыг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *БНМАУ-ын иргэдийн хувийн өмч*

92-р зүйл. БНМАУ-ын иргэдийн хувийн өмчийн эрх

БНМАУ-ын иргэд хувийн өмчтэй байх эрхтэй.

93-р зүйл. БНМАУ-ын иргэдийн хувийн өмчлөлийн зүйлс

БНМАУ-ын иргэдийн хувийн өмчид газар, үйлдвэрлэлийн хэрэгсэл, бусад эд хөрөнгө, түүнчлэн оюуны үнэт зүйлс байж болно.

Газрыг хувьдаа өмчлөх журмыг БНМАУ-ын газрын тухай хууль тогтоомжоор тодорхойлно.

94-р зүйл. Иргэдээс өмчлөх эрхээ хэрэгжүүлэх бусад хэлбэр

Хувийн үйлдвэрийн газар иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

Иргэд хувь хөрөнгөө нийлүүлэх замаар байгуулсан үйлдвэрийн газар, байгууллагын эд хөрөнгийг өмчлөх эрхээ өөрсдөө буюу төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтийн өмч*

95-р зүйл. Төрийн өмч

Төрийн өмчид газар, түүний хэвлий, ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад баялаг байна. Түүнчлэн үйлдвэрлэлийн хэрэгсэл, бусад эд юмс, оюуны үнэт зүйлс байж болно.

Төрийн өмчлөлийн зүйлсийг БНМАУ-ын төрийн эрх барих дээд байгууллага, түүний эрх олгосон байгууллага БНМАУ-ын хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулна.

Төрийн үйлдвэрийн газар, байгууллага нь өөртөө олгогдсон эд хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.



96-р зүйл. Иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллагын өмч

Иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол дүрэмд заасан үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах өөрийн хөрөнгөөр байгуулсан үйлдвэрийн газар, байгууллагын эд хөрөнгө болон бусад эд хөрөнгийг өмчлөх эрхтэй.

Иргэдийн хоршоолол, олон нийтийн байгууллага өмчлөх эрхээ хууль, дүрэмд заасан эрх хэмжээнийхээ дагуу ажиллаж байгаа өөрийн байгууллагаараа дамжуулан хэрэгжүүнэ.

97-р зүйл. Шашны байгууллагын өмч

Шашны байгууллага үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах барилга, шүтээн, буян үйлдэх зүйл, сүсэгтний өргөл барьц, мал, өөрийн хөрөнгөөр бий болгосон, иххүд байгууллага, хүмүүстээ хандивласан болон бусад эд хөрөнгө, түүнчлэн оюуны үнэт зүйлсийг өмчлөх эрхтэй.

Шашны байгууллага өмчлөх эрхээ хууль, дүрэмд заасан эрх хэмжээнийхээ дагуу ажиллаж байгаа өөрийн байгууллагаараа дамжуулан хэрэгжүүнэ.

98-р зүйл. Хандивласан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах

Төр, иргэдийн хоршоолол, олон нийт, шашны байгууллагад иргэд, байгууллагаас хандив өргөх, хандивласан эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журмыг БНМАУ-ын Засгийн газар тогтооно.

98<sup>1</sup>-р зүйл. Төр, иргэдийн хоршоолол, олон нийт, шашны байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

Төр, иргэдийн хоршоолол, олон нийт, шашны байгууллагын БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд хориглон зааснаас бусад эд хөрөнгөөс төлбөр гаргуулж болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Гадаадын иргэд, хуулийн этгээд, гадвал улс болон олон улсын байгууллагын өмч*

99-р зүйл. Гадаадын иргэдийн өмч

Гадаадын иргэд нь өмчлөлийн зүйлсийг БНМАУ-ын хууль,

БНМАУ-ын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр тус улсын иргэдийн нэгэн адил өмчлөх эрх эдэлнэ.

Энэ зүйл харьяалаагүй хүмүүст нэгэн адил хамаарна.

*100-р зүйл.* Гадаадын хуулийн этгээдийн өмч

Гадаадын хуулийн этгээд нь БНМАУ-ын хууль, БНМАУ-ын олон улсын гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу БНМАУ-ын нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор өмчлөлийн зүйлсийг БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр өмчлөх эрхтэй.

*101-р зүйл.* Олон улсын байгууллагын өмч

Олон улсын байгууллага нь БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах өмчлөлийн зүйлсийг БНМАУ-ын хууль, БНМАУ-ын олон улсын гэрээний дагуу өмчлөх эрх эдэлнэ.

*102-р зүйл.* Гадаадын иргэд, хуулийн этгээд, олон улсын байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах

Гадаадын иргэд, хуулийн этгээд, олон улсын байгууллагын эд хөрөнгөөс төлбөр гаргуулах журмыг БНМАУ-ын хууль, БНМАУ-ын олон улсын гэрээгээр тодорхойлно.

Энэ зүйл харьяалаагүй хүмүүст нэгэн адил хамаарна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

*Өмчлөх эрхийн баталгаа, иргэний эрх зүйн хамгаалалт*

*103-р зүйл.* Өмчлөх эрхийн баталгаа, иргэний эрх зүйн хамгаалалт

Төр нь өмчийн төрөл, хэлбэрийн ялгааг харгалзахгүйгээр өмчлөх эрхийг хамгаалах хууль зүй, эдийн засгийн болон бусад адил нөхцөлийг бүрдүүлж уг эрхийг баталгаажуулна.

Өмчлөгчийн өмчлөх эрхийг бусад бүх этгээд зөрчихгүй байх үүрэгтэй.

*104-р зүйл.* Бусдын хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө шаардан нэхэмжлэх

Өмчлөгч эд хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардан нэхэмжлэх эрхтэй.

Эд хөрөнгийг хууль бусаар эзэмшигч нь эзэмшлээ хууль бус болохыг мэдээгүй бөгөөд мэдэх аргагүй байсан, мөн эд хөрөнгийг түүнд өгсөн этгээд нь уул эд хөрөнгийг бусдад өгөх эрхгүй болохыг мэдээгүй бөгөөд мэдэх аргагүй байсан бол түүнийг учир мэдээгүйгээр эзэмшигч гэж үзнэ. Өмчлөгч буюу хууль ёсоор эзэмшигч нь эд хөрөнгөө өөрийн хүсэл зоригоос гадуур аадсан байвал уул эд хөрөнгийг үнэ төлбөртэй олж авсан учир мэдээгүйгээр эзэмшигчээс шаардан нэхэмжлэх эрхтэй. Хэрэв эд хөрөнгө олж авахдаа уул эд хөрөнгийг бусдад өгөх эрхгүй этгээдээс үнэ төлбөргүй авсан бол өмчлөгч хэдийд ч шаардан нэхэмжлэх эрхтэй.

Мөнгө, үнэт цаасыг учир мэдээгүйгээр олж авсан этгээдээс уул мөнгө, үнэт цаасыг шаардан нэхэмжилж болохгүй.

*105-р зүйл.* Хууль бусаар эзэмшигч эд хөрөнгийн орлогыг төлөх, өмчлөгчид хохирлыг төлөх

Өмчлөгч нь бусдын хууль бус эзэмшлээс эд хөрөнгөө шаардан нэхэмжлэхдээ учир мэдсэн эзэмшигчээс уул эд хөрөнгийг эзэмшиж байсан хугацаандаа авсан ба авах ёстой байсан орлогыг шаардан авах эрхтэй. Харин учир мэдээгүйгээр эзэмшигчээс уул эд хөрөнгийг хууль бус эзэмшиж байгаагаар мэдсэн буюу мэдэх ёстой байснаас хойшхи, эсхүл өмчлөгч нь эд хөрөнгөө буцаан нэхэмжилсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойшхи хугацаанд уул эд хөрөнгөөс авсан буюу авах ёстой байсан орлогыг шаардан авах эрхтэй.

Эд хөрөнгө эзэмшигч нь түүний орлогыг өмчлөгчид шилжүүлэх болсон цагаас хойш уул эд хөрөнгөд зарцуулсан зайлшгүй зардлыг өмчлөгчөөс шаардан нэхэмжлэх эрхтэй. Эд хөрөнгө эзэмшигч нь хийсэн засварынхаа зүйлийг уул эд хөрөнгөд гэмтэл учруулахгүйгээр салгаж өөртөө үлдээх эрхтэй. Хэрэв салгаж болохгүй бол учир мэдээгүйгээр эзэмшигч нь хийсэн засварынхаа үнийг уул эд хөрөнгөд засвар хийсний үр дүнд нэмэгдсэн үнээс хэтрүүлэхгүй нэхэмжилж болно.

*106-р зүйл.* Өмчлөх эрх зөрчигдсөн явдлыг арилагах

Өмчлөгч нь эд хөрөнгөө эзэмших явдалтай холбоогүй боловч өмчлөх эрх нь ямар нэг хэлбэрээр зөрчигдсэн бол уг зөрчлийг арилгуулахыг шаардах эрхтэй.

*107-р зүйл.* Өмчлөх эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй үйлдлийг зогсоохыг шаардах

Өмчлөгч нь өмчлөх эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй аливаа үйлдлийг зогсоохыг шаардах эрхтэй.

108-р зүйл. Эд хөрөнгийг хууль ёсоор эзэмшигчийн эрхийг хамгаалах

Энэ хуулийн 104—107 дугаар зүйлд заасан эрх нь өмчлөгч биш боловч эд хөрөнгийг хууль буюу гэрээ ёсоор эзэмшиж байгаа этгээдэд нэгэн адил хамаарна.»

3. БНМАУ-ын иргэний хуулийн IV хэсгийн «Эд хөрөнгө хөдсөлх» гэсэн гуравдугаар бүлгийг «Эд хөрөнгө хөдсөлх, түрээслэх» гэж өөрчлөн нэрлэж, уг бүлэгт дор дурдсан агуулгатай 198<sup>1</sup>, 198<sup>2</sup>, 198<sup>3</sup>, 198<sup>4</sup>, 198<sup>5</sup>, 198<sup>6</sup>, 198<sup>7</sup>, 198<sup>8</sup>, 198<sup>9</sup>, 198<sup>10</sup>, 198<sup>11</sup>, 198<sup>12</sup>, 198<sup>13</sup>, 198<sup>14</sup>, 198<sup>15</sup> дугаар зүйлүүдийг нэмсүгэй:

«198<sup>1</sup>-р зүйл. Газар, эд хөрөнгө түрээслэх гэрээ

Эд хөрөнгө түрээслэх гэрээгээр түрээслүүлэгч (өмчлөгч буюу өмчлөгчөөс эрх олгосон этгээд) нь түрээслэгчид газар, ой, ус, мал, амьтан, үйлдвэрлэлийн бусад хэрэгсэл, эд хөрөнгийг зохих болзол, төлбөртэйгээр тодорхой хугацаагаар эзэмшүүлэх, ашиглуулах үүрэг хүлээнэ.

198<sup>2</sup>-р зүйл. Түрээсийн гэрээний хэлбэр

Түрээсийн аливаа гэрээ бичгээр байна. Талууд хүсвэл гэрээг нотарнатаар гэрчлэн батлуулж болно.

198<sup>3</sup>-р зүйл. Түрээсийн гэрээний хугацаа

Түрээсийн гэрээний хугацааг түрээсэлж буй эд хөрөнгийн шинж байдал, зориулалтаас хамааруулан талууд харилцан тохиролцон.

198<sup>4</sup>-р зүйл. Түрээсийн гэрээг өөрчлөх, цуцлах

Хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрээний үүргийг биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээг өөрчлөх буюу цуцлахыг аль нэг тал нь шаардах эрхтэй.

198<sup>5</sup>-р зүйл. Түрээсийн гэрээг өөрчлөхгүй буюу цуцлахгүй байх

Талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах шалтгаанаар түрээслүүлэгч, түрээслэгч солигдох нь түрээсийн гэрээг цуцлах, гэрээний нөхцөлийг өөрчлөх үндэс болохгүй.

Эд хөрөнгийг эрх залгамжлан түрээсэлж болно.

198<sup>6</sup>-р зүйл. Түрээсийн төлбөр

Түрээсийн төлбөрийг талууд тохиролцож тогтооно.

Мөрдөж байгаа үнэ тариф өөрчлөгдөх, байгалийн гамшиг, гэнэтийн аюул тохиолодох болон талуудын үйл ажиллагаанаас хамаарахгүй шалтгаанаар түрээслэсэн эд хөрөнгийн чанар, бай-

даа алдагдвал талууд харилцан тохиролцож түрээсний төлбөрийн хэмжээг өөрчилж болно.

*198<sup>7</sup>-р зүйл. Түрээслүүлэгчийн үүрэг*

Түрээслүүлэгч нь гэрээний нөхцөлд тохирсон эд хөрөнгийг түрээслэгчид шилжүүлэх; эд хөрөнгөнд их засвар хийх үүрэгтэй. Үүнээс бусад үүргийг талууд тохиролцон гэрээнд тодорхойлож болно.

*198<sup>8</sup>-р зүйл. Түрээслэгчийн үүрэг*

Түрээслэгч нь түрээслэн авсан эд хөрөнгийг гэрээнд заасны дагуу эзэмших, ашиглах; газрын үржил, малын ашиг шим, эд хөрөнгийн чанар, байдлыг алдагдуулахгүй байх, нөхөн сэргээх; түрээсний төлбөрийг хугацаанд нь төлөх; хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээний хугацаа дуусгавар болсны дараа түрээслэн авсан эд хөрөнгийг түрээслүүлэгчид хүлээлгэн өгөх үүрэг хүлээнэ. Эдгээрээс бусад үүргийг талууд тохиролцон гэрээнд тодорхойлож болно.

*198<sup>9</sup>-р зүйл. Түрээслүүлэгч, түрээслэгчийн давуу эрх*

Түрээслүүлэгч нь гэрээ байгуулахаар хэд хэдэн этгээд санал гаргасан тохиолдолд түрээслэгчийг сонгож авах; түрээслэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон, эд хөрөнгө эзэмших найдваргүй байдал илэрсэн тохиолдолд гэрээг цуцлах буюу учирсан хохирлыг төлөхийг шаардах эрхтэй.

Түрээслэгч нь хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол түрээслэн авсан эд хөрөнгийг дамжуулан түрээслэх; түрээслэсэн эд хөрөнгийг түрээслүүлэгч худалдах тохиолдолд тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй. Талууд тохиролцон бусад давуу эрхийг гэрээгээр тогтоож болно.

*198<sup>10</sup>-р зүйл. Түрээслэх эд хөрөнгийг үнэлэх*

Түрээслэж байгаа эд хөрөнгийг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол талуудын тохиролцсоноор үнэлнэ.

*198<sup>11</sup>-р зүйл. Түрээслэсэн эд хөрөнгийг худалдах буюу үнэ төлбөргүй шилжүүлж болох*

Түрээсний гэрээний хугацаа дуусгавар болсны дараа түрээслэсэн эд хөрөнгийг дахин үнэлэх замаар худалдах, эсхүл үнэ төлбөргүй шилжүүлэх эсэхийг талууд тохиролцох эрхтэй.

*198<sup>12</sup>-р зүйл. Газрыг түрээслэх*

Газрыг түрээслэх эрх нь газрын хэвлийг эзэмших, ашиглахад хамаарахгүй.

Газар түрээслэх гэрээний хугацаа нь арван таван жилээс доошгүй байна.

Газрыг түрээслэх гэрээний хугацаа дууссаны дараа дахин түрээслүүлэх үед тэргүүн ээлжинд түрээслэн авах эрхийг өмнөх түрээслэгч эдэлнэ.

Газрыг эрх залгамжлан түрээсэлж болно.

*198<sup>12</sup>-р зүйл.* Түрээсийн эд хөрөнгийн даатгал

Түрээслэсэн эд хөрөнгийг даатгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг талууд тохиролцон гэрээнд тусгаж зохицуулна.

*198<sup>11</sup>-р зүйл.* Хамтран түрээслэх

Хэд хэдэн этгээд эд хөрөнгө хамтран түрээслэх тохиолдолд түрээслэгчдийн хоорондын харилцааг тэдний хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээгээр зохицуулна. Хамтран түрээслэсэн нөхцөлд түрээслэгч бүр эрхээ хамгаалахыг бие даан шаардах эрхтэй.

*198<sup>15</sup>-р зүйл.* Түрээсийн гэрээний үүрэг биелүүлээгүйн үр дагавар

Түрээсийн гэрээний үүргийг биелүүлээгүй бол хууль буюу гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.»

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 1 дүгээр  
сарын 8-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай БНМАУ-ын  
хуулийг зөвшөөрөн батламжиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

# БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХУУЛЬ

1991 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

## БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

Улс орны эдийн засгийн байдлыг тогтворжуулах шаардлагатай шуурхай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж байх, болзошгүй сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын эдийн засгийн амьдрал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад нэн чухал үүрэг бүхий тодорхой үйлдвэрийн газар, байгууллагад шаардлагатай гэж үзвэл нийтлэг баримтаадаг хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр 6 сар хүртэл хугацаагаар тусад нь онцгой дэглэм тогтоож, харьяалад харгалзахгүйгээр өөрийн шууд хяналтад авч ажиллуулах эрхийг БНМАУ-ын Засгийн газарт олгосугай.

2. Онцгой дэглэмээр ажиллах үйлдвэрийн газар, байгууллагын үйл ажиллагааны талаар Засгийн газраас тогтоох эрх зүйн онцгой журам нь БНМАУ-ын хууль тогтоомжийн ардчилсан зарчим, БНМАУ-ын олон улсын гэрээний үндэслэл, иргэдийн нийтлэг ашиг сонирхолд нийцсэн байхын зэрэгцээгээр дор дурдсан асуудлын хүрээнд байвал зохино:

1) үйлдвэрийн газар, байгууллагын зохион байгуулалтын бүтэц, үүргийг тогтоох, бүх шатных нь удирдах ажлалтынг томилгох;

2) ажлын өдөр, цагийн дэглэм, ээлжийг өөрчлөн тогтоох;

3) хөдөлмөрийн норм, цалин хөлсийг шинэчлэн тогтоох, өөрчлөх;

4) үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгаалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад нь тусгай хяналт тогтоох;

5) Засгийн газраас тогтоосон онцгой журмыг хэрэгжүүлэхэд саад учруулсан улс төр, олон нийтийн байгууллагын үйл ажиллагааг тухайн үйлдвэрийн газар, байгууллага дээр түр зогсоож, хяналт тогтоох;

6) тухайн үйлдвэрийн газар, байгууллагад хөдөлмөр, үйлдвэрлэл, технологийн сахлагыг чанд сахин биелүүлэхэд чиглэ-



сэн хөдөлмөрийн сахилгын тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахнуулах тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдэд харьцаал харгалзахгүйгээр зохих хариуцлага хүлээлгэх;

7) онцгой дэглэмтэй үйлдвэрийн газар, байгууллагын хэвийн ажиллагаа аадагдахад хүрвэл хүн хүч, тээврийн хэрэгслийн дайчилгаа явуулах;

8) онцгой дэглэмтэй үйлдвэрийн газар, байгууллагаас бусадтай байгуулсан гэрээний болзлыг зайлшгүй шаардлагатай тохиолдолд захиалагч (баатгэн нийлүүлэгч)-ийн хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүйгээр өөрчлөх буюу гэрээг цуцлуулах;

9) улсын захиалага, даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд тухайн үйлдвэрийн газар, байгууллага, түүний эрх баригчдэд хүлээлгэх эдийн засгийн болон захиргааны хариуцлагын арга хэмжээ тогтоож хэрэглэх;

10) хүн амын хүнсний болон өдөр тутмын хэрэглээний ховор олдоцтой барааг хуваарилах, тээвэрлэх, худаадан борлуулах, хил нэвтрүүлэх тусгай журам тогтоож, тэдгээр барааг дамлан худалдах, шунахай зорилгоор их хэмжээтэй нөөцлөх зэргээр дотоод зах зээлд барааны хомсдлыг зориуд бий болгохтой тэмцэхэд чиглэгдсэн захиргааны урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон хариуцлагын арга хэмжээ тогтоон хэрэглэх.

3. Үйлдвэрийн газар, байгууллагад тогтоосон онцгой дэглэм, хэрэгжилтийн нь явцыг сар бүр Улсын Бага Хурал, олон түмэнд мэдээлж байх, онцгой дэглэмийн хугацааг сунгах шаардлагатай гэж үзвэл саналаа Улсын Бага Хуралд оруулж шийдвэрлүүлж байхыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

4. Энэ хуулийг БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
парийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 1 дүгээр

сарын 9-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар

хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Харьгатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ**

1991 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

**БНМАУ-ЫН ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛИНД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны 217 А (III) тоот тогтоолоор баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 15 дугаар зүйлийн 1-д «Хүн бүр иргэний харьяалалтай байх эрхтэй», 2-т «Хэнийг ч иргэний харьяаллаас нь буюу иргэний харьяаллаа өөрчлөх эрхээс нь дур мэдэн хасч болохгүй» гэж тунхагласныг анхааралдаа авч, хүний иргэний харьяалалтай байх эрхийг хангах үүднээс БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын Харьяатын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалт, 17 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**БНМАУ-ын Бага Хурлын  
дарга**

**Р. ГОНЧИГДОРЖ**

**БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга**

**Б. ЧИМИД**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛААМЖ**

1991 оны 1 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 3

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас батласан БНМАУ-ын Ерөнхий-  
логчийн тухай хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЯ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Нийтлэл үндэслэл*

*1 дүгээр зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгч*

БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн.

*2 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийг сонгох*

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр нэр дэвшигч нь 40 насанд хүрсэн, монголын ард түмний аж амьдрал, ёс заншлыг сайн мэддэг, сүүлийн 5-аас доошгүй жил БНМАУ-д байнга оршин сууж байгаа БНМАУ-ын иргэн байна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгчийг БНМАУ-ын Ардын Их Хурлаас саналаа нууцаар гаргаж, нийт депутатын олонхийн саналаар сонгоно.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа улируулан сонгож болно.

*3 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тангараг*

1. БНМАУ-ын Ерөнхийлөгч «БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, ард түмнийхээ үндэсний эв нэгдлийг тууштай хамгаалж, БНМАУ-ын Үндсэн хуулийг дээдлэн сахиж БНМАУ-ын Ерөнхийлөгчийн үүргийг шударгаар биелүүлэхээ батлан тангараглаж байна гэж» БНМАУ-ын Ардын Их Хуралд тангараг өргөнө.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг БНМАУ-ын Ардын Их Хурал тогтооно.

*4 дүгээр зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа*

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь тангараг өргөсөн өдрөөс эхэлж БНМАУ-ын шинэ Ерөнхийлөгч тангараг өргөсөн өдөр дуусгавар болно.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дор дурдсан тохиолдолд хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

1) биеийн эрүүл мэндийн байдлаар болон бусад шалтгаанаар хүсэлтээ гаргаж чөлөөлөгдсөн;

2) БНМАУ-ын Ерөнхийлөгч өргөсөн тангарагас няцаж БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийг зөрчвөл БНМАУ-ын Ардын Их Хурал нийт депутатын гуравны хоёроос доошгүйн саналаар огцруулсан.

5 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгч ажлаа хариуцан тайлагнах

БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын Ардын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнана.

БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын Ардын Их Хуралд 2 жил тутамд 1 удаа ажлын тайлангаа тавьж хэлэлцүүлэх боловч БНМАУ-ын Ардын Их Хурлын нийт депутатын гуравны нэгээс доошгүй нь шаардвал хэнийд ч тайлангаа тавьж болно.

6 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгч хавсарч болохгүй албан тушаал

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалыг бүх шатны Ардын Хурлын депутат, БНМАУ-ын Бага Хурлын гишүүн болон БНМАУ-ын Үндсэн хуулиар үүрэгт нь хамаарахгүй цааштай буюу цаашиггүй өөр төрлийн ажил, албан тушаалтай хавсарч болохгүй.

Хэрэв аль нэг шатны Ардын Хурлын депутат, эсхүл БНМАУ-ын Бага Хурлын гишүүн БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр нэр дэвшигдвэл депутатын болон БНМАУ-ын Бага Хурлын гишүүний үүргээс чөлөөлөгдөх эсэх талаар саналаа илэрхийлэх ёстой бөгөөд тийнхүү БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдвол БНМАУ-ын Ардын Их Хуралд тангараг өргөсөн өдрөөс эхлэн уул үүргээс чөлөөлөгдсөнд тооцно.

7 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны удирдамж

БНМАУ-ын Ерөнхийлөгч өргөсөн тангарагтаа үнэнч байж, БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуулийг нарийн чанд сахин ажиллана.

8 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж

1. БНМАУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргана.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг бүх нийтээр даган мөрдөнө. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигт тодорхой хугацаа заагаагүй бол гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

#### 9 дүгээр зүйл. БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч

1. БНМАУ-ын Дэд ерөнхийлөгчийг БНМАУ-ын Ерөнхийлөгчийн санал болгосноор БНМАУ-ын Ардын Их Хурлаас саналаа нууцаар гаргаж нийт депутатын олонхийн саналаар сонгоно.

2. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 3-т заасан болон БНМАУ-ын Ерөнхийлөгч нас барсан тохиолдолд БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрх БНМАУ-ын Дэд ерөнхийлөгчид шилжих бөгөөд Дэд ерөнхийлөгч БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тагараг өргөнө. Энэ тохиолдолд БНМАУ-ын Дэд ерөнхийлөгчийг нөхөн сонгоно.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгч түр эзгүйд түүний бүрэн эрхийг БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч хэрэгжүүлнэ.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### *БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрх*

10 дугаар зүйл. Улс орны удирдлагын асуудлаарх бүрэн эрх

БНМАУ-ын Ерөнхийлөгч улс орны удирдлагын асуудлаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) хууль тогтоох болон гүйцэтгэн захирамжаах дээд байгууллагуудын харицан үйл ажиллагааг зохицуулж чиглүүлэх;

2) төрийн бодлогын ямар ч асуудлаар саналаа БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хуралд оруулах;

3) БНМАУ-ын Засгийн газрын тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх явдамг тодорхой шалтгаанаар түдгэлзүүлэх, энэ тухай үндэслэлээ БНМАУ-ын Засгийн газарт мэдэгдэж, шаардлагатай бол БНМАУ-ын Бага Хуралд мэдүүлэх;

4) хууль санаачлагчаас БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар санал өгөх, энэ нь уг хуулийг батламжлах буюу хориг тавихад нь саад болохгүй;

5) БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдаан, БНМАУ-ын Бага Хурлын чуулган, БНМАУ-ын Засгийн газрын хуралдаанд өөрийн үзэмжээр хэзээ ч оролцож үг хэлэх.

*11 дүгээр зүйл.* Төрийн байгуулалтын талаарх бүрэн эрх.

БНМАУ-ын Ерөнхийлөгч төрийн байгуулалтын талаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) бүх шатны Ардын Хурлын депутатуудын ээлжит, түүнчлэн БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатуудын нөхөн бодон орон нутгийн Ардын Хурлын депутатуудын шинэ сонгуулийг товлон зарлах;

2) БНМАУ-ын Дэд ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх саналаа БНМАУ-ын Ардын Их Хуралд, БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын Ерөнхий прокурорыг томилж, чөлөөлөх, БНМАУ-ын Дэд шүүхийн даргыг сонгох, чөлөөлөх саналаа БНМАУ-ын Ардын Их Хуралд буюу БНМАУ-ын Бага Хуралд оруулах;

3) шаардлагатай гэж үзвэл БНМАУ-ын Ерөнхий сайдыг огцруулах саналыг БНМАУ-ын Бага Хурлын даргатай зөвшөөрөлцөн БНМАУ-ын Ардын Их Хуралд, БНМАУ-ын Засгийн газрыг тараах саналыг БНМАУ-ын Ерөнхий сайдтай зөвшөөрөлцөн БНМАУ-ын Бага Хуралд тус тус оруулах;

4) хууль санаачлах;

5) БНМАУ-ын Ардын Их Хурлын ээлжит бус хуралдаан хийх санал оруулах;

6) БНМАУ-ын хүндэт цол, одон, медалиар шагнах, мөн цол, шагналыг хасах;

7) БНМАУ-ын цэргийн дээд цол, бусад алдар цол олгох, хасах;

8) уучлаа үзүүлэх.

*12 дугаар зүйл.* БНМАУ-ын харьяатын талаарх бүрэн эрх.

БНМАУ-ын Ерөнхийлөгч харьяатын талаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) БНМАУ-ын харьяат болгох, харьяатаас гаргах асуудлыг шийдвэрлэх;

2) БНМАУ-д орогнох эрх олгох.

*13 дугаар зүйл.* Гадаад харилцааны талаарх бүрэн эрх.

БНМАУ-ын Ерөнхийлөгч гадаад харилцааны асуудлаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) олон улсын харилцаанд БНМАУ-ыг төлөөлөх гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах шийдвэрийг батламжаах;

2) БНМАУ-ын нэрийн өмнөөс олон улсын хэлэлцээ хийж, гэрээ байгуулах;

3) БНМАУ-аас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүн 1, БНМАУ-ын Бага Хуралтай зөвлөлдсөнөөр томилж буюу эгүүлэн татах;



4) БНМАУ-д суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн итгэмжлэх, зүүлэн татах жуух бичгийг хүлээн авах.

*14 дүгээр зүйл.* БНМАУ-ын хууль батламжлах, түүнд болон БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын бусад шийдвэрт хориг тавих бүрэн эрх

1. БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын баталсан хуулийг гарын үсэг зурж батламжилна.

БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурал хуулийг баталснаас хойш ажлын 3 хоногийн дотор батламжуулахаар өргөн мэдүүлэх бөгөөд БНМАУ-ын Ерөнхийлөгч түүнийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор батламжилна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын баталсан хууль болон бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих бол хориг тавьсан нэгдүгээтэй хуулийг батламжуулахаар өргөн мэдүүлснээс нь хойш, бусад шийдвэрийг баталснаас нь хойш ажлын 10 хоногийн дотор уг хууль буюу шийдвэрийг баталсан байгууллагад хүргүүлнэ.

БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурал хоригийг хүлээж аваад ажлын 3 хоногийн дотор хэлэлцэж хэрхэхийг шийдвэрлэнэ. Хэрэв хоригийг дийлэнх олонхийн саналаар хүлээж аваагүй бол БНМАУ-ын Ерөнхийлөгч уг хуулийг нэг хоногийн дотор батламжилна.

БНМАУ-ын Ардын Их Хурлын болон БНМАУ-ын Бага Хурлын бусад шийдвэр нь БНМАУ-ын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваагүй тухай шийдвэр баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөрт тооцогдоно.

*15 дугаар зүйл.* Батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаарх бүрэн эрх

1. БНМАУ-ын Ерөнхийлөгч нь БНМАУ-ын Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч улс орны батлан хамгаалаат, аюулгүй байдлыг хангах зорилгоор дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) БНМАУ-ын Батлан хамгаалах зөвлөлийг байгуулан тологойлж, БНМАУ-ын Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүнийг захиран командлах;

2) БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул учирсан нөхцөлд дайны байдал зарлах, дайны байдалд оруулах журмыг БНМАУ-ын хуулиар тогтооно;

3) батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цэргийн байгууллагын эрх баригчдын илтгэл, мэдээллийг сонсох;

4) БНМАУ-ын Зэвсэгт хүчний захиран командлах тодорхой зарим эрхийг БНМАУ-ын Батлан хамгаалахын сайдад олгох.

*16 дугаар зүйл.* Оңц нөхцөл байдал үүссэн тохиолдолд эдлэх бүрэн эрх

1. БНМАУ-ын Ерөнхийлөгч улсын хэмжээнд, эсхүл түүний нутаг дэвсгэрийн зарим хэсэгт оңц байдал зарлах, нийтийн хэв журам сахиулах оңцгой арга хэмжээ авах эрхтэй. Эдгээр арга хэмжээг тогтоох, хэрэглэх журмыг БНМАУ-ын хуулиар зохицуулна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч оңц байдал тогтоосон, цуцалсан болон оңцгой арга хэмжээ авсан тухай ард түмэнд мэдэгдэнэ.

*17 дугаар зүйл.* БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх

БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, халдашгүй дархан байдал*

*18 дугаар зүйл.* БНМАУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл

БНМАУ-ын Ерөнхийлөгч БНМАУ-ын Үндсэн хууль болон энэ хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүх бололцоо нөхцөлөөр хангагдана.

*19 дүгээр зүйл.* БНМАУ-ын Ерөнхийлөгчийн ажлын аппарат, ажлын хэсэг

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн ажлын аппарат нь БНМАУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар мөн.

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалингийн санг БНМАУ-ын Ерөнхийлөгч батална.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч үйл ажиллагаагаа явуулахад нь туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулаж болно.

20 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тамга, хэвлэл-лэмэл хуудас

БНМАУ-ын Ерөнхийлөгч тогтоосон журмын дагуу үйлдсэн БНМАУ-ын төрийн сүлд бүднй тамга, хэвлэл-лэмэл хуудас хэрэглэнэ.

21 дүгээр зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалын цалин, хангамж

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалын сарын цалинг БНМАУ-ын Ардын Их Хурал тогтооно.

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн албан ёсны айлчлага, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон төрийн ёслол, хүндэтгэлийн болон бусад арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны жилийн зардлын хэмжээг БНМАУ-ын Засгийн газрын саналыг үндэслэн БНМАУ-ын Бага Хурал тогтооно.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгч нийслэл хот болон хот орчмын газарт албаны өвөл, зуны өргөөтэй байна. Түүний зардал, үйлчилгээг улс хариуцна.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгч тусгай зориулалтын уналгын хэрэгслээр хангагдана.

4. БНМАУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаа дууссанаас эхлэн БНМАУ-ын Бага Хурлаас тогтоосон тэтгэвэр авч, хангамж эдэлнэ.

22 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн төрийн ёслолын хувцас

БНМАУ-ын Ерөнхийлөгч тэнгараг өргөх, улсмыхад үндэсний баярыг нээх, хаах, биеллийн улирлын хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг тохиолдуулан эрд түмэндээ хандаж үг хэлэх зэрэг төрийн ёслолын ажиллагааны үед төрийн ёслолын хувцастай байна.

23 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн халдашгүй дархан байдал

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн бие, бүрэн эрх, нэр төр, аалср хүнд, өргөө, уналгын хэрэгсэл халдашгүй дархан байна.

2. БНМАУ-ын Ерөнхийлөгчийг энэхүү Хуулийн 4 дүгээр зүйлийн 3-ын 2-д зааснаас бусад тохиолдолд эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, захиргааны шийтгэл оногдуулах, өргөө, албан тасалгва, уналгын

хэрэгсэлд нь болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгч улсын албан татвараас бусад албан дайчлаганаас чөлөөлөгдөнө.

4. БНМАУ-ын Ерөнхийлөгч, түүний өргөө, улаагын хэрэгсэл улсын хамгаалалтад байна. Түүнчлэн БНМАУ-ын Ерөнхийлөгчийн гэргий (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийг шаардлагатай үед улсын хамгаалалтад авна. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн биеийн эрүүл мэндийг онцлон хамгаална. БНМАУ-ын Ерөнхийлөгч бүрэн эрхийн хугацаа дууссанаас эхлэн БНМАУ-ын Бага Хурлаас тогтоосны дагуу улсын хамгаалалтад байна.

**24 дүгээр зүйл. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн нэр төр, алдар хүндийн баталгаа**

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн нэр төр, алдар хүндийг БНМАУ-ын хуулиар хамгаална.

БНМАУ-ын Бага Хурлын дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 ойн 1 дүгээр сарын 04-ний өдөр

Улаанбаатар хот

— 44 —

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 1 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 4

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Бага Хур-  
лын тухай хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

*Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* БНМАУ-ын Бага Хурал

БНМАУ-ын Бага Хурал (цаашид «Улсын Бага Хурал» гэх) нь хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага мөн.

*2 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын тухай хууль тогтоомж

Улсын Бага Хурлын тухай хууль тогтоомж нь БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль, мөн БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын бусад шийдвэрээс бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим

Улсын Бага Хурлын үйл ажиллагаа нь БНМАУ-ын тусгаар тогтнол, үндэсний эв нэгдэл, ард түмний нийтлэг эрх ашгийг эрхэмлэх, хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхийн саналаар шийдвэрлэх, олон түмний санаа бодлыг тусгах, ил тод байх зарчимд үндэслэнэ.

*4 дүгээр зүйл.* Улсын Бага Хурлын бүрэлдэхүүн

Улсын Бага Хурал нь БНМАУ-ын Ардын Их Хурлаас сонгогдсон дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 50 гишүүнээс бүрэлдэнэ.

*5 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын гишүүний андгай

Улсын Бага Хурлын бүрэлдэхүүн, мөн нөхөн сонгогдсон гишүүн БНМАУ-ын төрийн сүлдний өмнө

«Алд бие мину алжааваас алжаатугай

Аху төр мину бүү алдартугай

Бүтэн бие мину алжааваас алжаатугай

Бүрэн улс мину бүү алдартугай» гэж андгай өргөнө.

*6 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа

1. Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

2. Улсын Бага Хурлын бүрэн эрхийн хугацаа нь Улсын Бага Хурлыг сонгосон тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын шийдвэр гарсан өдрөөс эхэлж шинэ Улсын Бага Хурлыг сонгосон тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын шийдвэр гарсан өдөр дуусгавар болно.

3. Улсын Бага Хурлыг бүрэн эрхийн хугацаа нь дуусахаас өмнө БНМАУ-ын Ардын Их Хурлын нийт депутатуудын дийлэнх олонхийн саналаар тарааж болно.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### *Улсын Бага Хурлын бүрэн эрх*

*7 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын хууль тогтоох бүрэн эрх

Улсын Бага Хурал хууль тогтоох талаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) БНМАУ-ын Үндсэн хуулиас бусад хууль гаргах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, хүчингүй болсонд тооцох, хуулийн үйлчлэлийг түдгэлзүүлэх, хуулийн албан ёсны тайлбар гаргах;

2) БНМАУ-ын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах;

3) хуулийн төслийг шаардлагатай гэж үзвэл ард нийтээр хэлэлцүүлэх;

4) хууль санаачлах;

5) өршөөл үзүүлэх.

*8 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын хянан шалгах бүрэн эрх

Улсын Бага Хурал хянан шалгах талаар дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) БНМАУ-ын Үндсэн хууль, бусад хууль, БНМАУ-ын Ардын Их Хурлын болон Улсын Бага Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;

2) БНМАУ-ын Засгийн газар, аймаг, хотын Ардын Хурлын шийдвэрийг БНМАУ-ын хуульд нийцээгүй байвал хүчингүй болгох;

3) БНМАУ-ын Засгийн газрын бүрэн эрхийнхөө хугацаанд явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл, түүний хэрэгжилтийг хэлэлцэх;

4) БНМАУ-ын Засгийн газар, БНМАУ-ын Ерөнхий прокурор, БНМАУ-ын Дээд шүүхийн тайлан, аймаг, хотын Ардын Хурлын Төргүүлэгчид, шаардлагатай гэж үзвэл яам, ул-

сын хороо, тусгай газрын болон улсын банк, статистикийн байгууллаагийн нэтгэл хэвэлцэх;

5) БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэл, улсын нэгдсэн төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайланг хэвэлцэх;

6) улсын санхүү, зээлийн бодлогын үндсэн чиглэлийг тогтоох;

7) БНМАУ-ын хилийн бодлогын үндсэн чиглэлийг тогтоож, түүний хэрэгжилтийн байдалд хяналт тавих.

*9 дүгээр зүйл. Улсын Бага Хурлын зохион байгуулах бүрэн эрх*

Улсын Бага Хурал зохион байгуулах талаар дор дурдсан бүрэн эрх эдвэл:

1) БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдааныг зарлах;

2) БНМАУ-ын Ардын Их Хурлын чөлөө цагт түүнд дараа оруулан батлуулахаар БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын Ерөнхий прокурорыг томилж, чөлөөлөх, БНМАУ-ын Дээд шүүхийн даргыг сонгох, чөлөөлөх;

3) БНМАУ-ын Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг батлах, түүнд өөрчлөлт оруулах, БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн цалин, хангамжийг нь тогтоох;

4) БНМАУ-ын Засгийн газарт нтгэл хүлээлгэж байгаа эсэхээ нлэрхийлэх, шаардлагатай гэж үзвэл түүнийг огцруулах;

5) БНМАУ-ын Дээд шүүхийн даргын өргөн мэдүүлснээр Дээд шүүхийн бүрэлдэхүүн болон тусгай шүүхийн шүүгчдийг сонгох, тэдгээрт өөрчлөлт оруулах;

6) БНМАУ-ын Ерөнхий прокурорын өргөн мэдүүлснээр түүний орлогч нарыг томилж, чөлөөлөх;

7) БНМАУ-ын Засгийн газрын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын засаг захиргаа-нутаг дэвсгэрийн хуваарьт өөрчлөлт оруулах;

8) орон нутгийн Ардын Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, үйл ажиллагааг нь чиглүүлэх;

9) нийгэм, төрийн амьдралын нэн чухал асуудлыг ард нийтээр хэвэлцүүлэх;

10) ард нийтийн санал хураалт явуулах;

11) гадаад улстай дипломат харилцаа тогтоох, таслах;

12) БНМАУ-ын хүндэт цол, одон, медаль, цэргийн дээд цол, бусад алдар цол бий болгох, хүчингүй болгох;

13) дайн зарлах, энх тайван тогтоох.

*10 дүгээр зүйл. Улсын Бага Хурлын бусад бүрэн эрх*

Улсын Бага Хурал нь дээр дурдсан болон БНМАУ-ын хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна



БНМАУ-ын Ардын Их Хурлын эрх хэмжээнд хамаарахаар хуульд зааснаас бусад төрийн дотоод, гадаад бодлогын ямар ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Улсын Бага Хурлын чуулган

#### 11 дүгээр зүйл. Чуулган

Улсын Бага Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын гол хэлбэр нь чуулган мөн.

#### 12 дугаар зүйл. Ээлжит чуулган

1. Улсын Бага Хурлын ээлжит чуулганыг хагас жилд нэг удаа, ажлын 75 хоног хүртэл хугацаатайгаар хийнэ. Ээлжит чуулганыг биеллийн тооллын хаврын дунд сарын шинийн 3, намрын дунд сарын 17-ны өдөр тус тус нээнэ.

2. Улсын Бага Хурлын ээлжит чуулган нээх өдөр нь амралт, баяр ёслолын өдөр таарвал түүнийг дараагийн өдөрт шилжүүлнэ.

#### 13 дугаар зүйл. Ээлжит бус чуулган

1. Улсын Бага Хурлын ээлжит бус чуулганыг дор дурдсан тохиолдолд хийнэ:

1) БНМАУ-ын Ардын Их Хурлын шийдвэр, Улсын Бага Хурлын гишүүдийн олонхийн санал, Улсын Бага Хурлын даргын санаачлагаар;

2) БНМАУ-ын Ерөнхийлөгч, БНМАУ-ын Засгийн газар, эсхүл Улсын Бага Хурлын гишүүдийн гуравним нэгийн саналыг үндэслэн Улсын Бага Хурлын даргын шийдвэрээр.

2. Улсын Бага Хурлын дарга Улсын Бага Хурлын ээлжит бус чуулганыг хуралдуулах тухай захирамж гаргах бөгөөд энэ тухай ажлын 5 хоногт багтаан Улсын Бага Хурлын гишүүдэд мэдэглэнэ.

#### 14 дүгээр зүйл. Чуулганаар асуудал хэлэлцэх

1. Хууль санаачлах эрх бүхий этгээдийн оруулсан асуудлыг Улсын Бага Хурал хэлэлцэнэ. Харин ийм эрхгүй байгууллага, иргэд нь хууль санаачлах эрхтэй этгээдээр уламжлан Улсын Бага Хуралд хэлэлцүүлэхээр асуудал оруулж болно.

2. Улсын Бага Хурлын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудлыг хууль санаачлагч хэлэлцэхээс 30 хоногийн өмнө

Улсын Бага Хуралд оруулсан байвал зохино. Энэ хугацаанд оруулаагүй асуудлыг тухайн чуулганаар хэлэлцэхгүй байж болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Улсын Бага Хурлын байнгын хороо болон бусад байгууллага*

*15 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын байнгын хороо

1. Улсын Бага Хурлын байнгын хороо (цаашид «байнгын хороо» гэх) нь Улсын Бага Хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангах, түүний шийдвэрлэх асуудлаар бодлого боловсруулах, санал, дүгнэлт гаргах, түүнчлэн тус тусын эрхлэх асуудлын хүрээнд Улсын Бага Хурлын хянан шалгах, зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлэх зорилго бүхий ажлын байгууллага мөн.

2. Байнгын хорооны тодорхой эрх, үүрэг, үйл ажиллагааны журмыг Улсын Бага Хурал тогтооно.

*16 дугаар зүйл.* Байнгын хорооны бүрэлдэхүүн

Улсын Бага Хурал байнгын хороог дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр Улсын Бага Хурлын гишүүдээс сонгон байгуулна. Байнгын хорооны төрөл, бүрэлдэхүүний тоог Улсын Бага Хурал тогтооно.

*17 дугаар зүйл.* Байнгын хорооны үндсэн бүрэн эрх

Байнгын хороо эрхлэх ажлынхаа хүрээнд дор дурдсан үндсэн бүрэн эрх эдэлнэ:

- 1) хууль санаачлах;
- 2) Улсын Бага Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар санал өгөх, дүгнэлт гаргах;
- 3) БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг шалгаж хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

4) шаардлагатай гэж үзвэл саналаа БНМАУ-ын Засгийн газарт оруулах, БНМАУ-ын Засгийн газрын гишүүд, БНМАУ-ын Ардын Их Хурлаас байгуулагддаг бусад байгууллагын удирдах албан тушаалтны нэгдэл, сонголыг хэлэлцэх, гэдэнд асуулта, асуулт тавих бөгөөд асуулын хариуг 30 хоногийн дотор бичгээр шаардан авах, энэ талаар гарсан маргааныг Улсын Бага Хурлаар шийдвэрлүүлэх.

*18 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын бусад байгууллага

Улсын Бага Хурал ажлын шаардлагыг харгалзан түр, дэд хороо, ажлын хэсэг байгуулж, тэдгээрийн эрх, үүрэг, үйл ажиллагааны журмыг тогтоож болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрх*

*19 дүгээр зүйл.* Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1. Улсын Бага Хурлын гишүүн бүрэн эрхээ БНМАУ-ын Ардын Их Хурлаас сонгосон тухай тогтоол гарсан өдрөөс эхлэн хэрэгжүүлнэ.

2. Улсын Бага Хурал нь БНМАУ-ын Ардын Их Хуралд дараа оруулан батлуулахаар гишүүнийхээ бүрэн эрхийг дор дурдсан тохиолдолд БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдаан хүртэл түдгэлзүүлж болно:

1) БНМАУ-ын Ерөнхий сайд, БНМАУ-ын Засгийн газрын гишүүн, БНМАУ-ын Ерөнхий прокуророор томилогдсон, БНМАУ-ын Дээд шүүхийн даргаар сонгогдсон;

2) биеийн эрүүл мэндийн байдлаас болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос чөлөөлж өгөхийг хүсч өргөдөл гаргасан;

3) БНМАУ-ын Ардын Их Хурлын депутатаас огцорсон.

3. Улсын Бага Хурлын гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болбол түүнийг огцорсонд тооцно.

4. Улсын Бага Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуулиар тогтоогдсон үүрэгт нь хамаарахгүй цалинтай буюу цалингүй өөр төрлийн ажил, албан тушаалыг хавсарч болохгүй.

*20 дугаар зүйл.* Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрх

1. Улсын Бага Хурлын гишүүн БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх эдэлж БНМАУ-ын Ардын Их Хурал, Улсын Бага Хуралд ажлаа тайлагнана.

2. Улсын Бага Хурлын гишүүн Улсын Бага Хурлын чуулган, байнгын хорооны хуралдаанд оролцохдоо дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

- 1) аливаа асуудлыг хэлэлцэхэд таслах эрхтэй оролцох;
- 2) Улсын Бага Хурлын байнгын хороо болон бусад байгууллагыг сонгох буюу тэдгээрт сонгогдох.

Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга нь Улсын Бага Хурлын байнгын хороо болон бусад байгууллагад сонгогдохгүй;

- 3) хууль санаачлах, тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр бие даан боловсруулж оруулах;

- 4) хэлэлцэж байгаа асуудлын талаар илтгэгчээс асуух, санал, шүүмжлэл гаргах, саналынхаа үндэслэлийг танилцуулах, хэлсэн үг, тайлбар, дүгнэлтээ ийнхүү үзэх;

- 5) гаргасан санал, тавьсан асуултад харнулт авах;

- 6) хэлэлцэж байгаа асуудлаар БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын тогтоол, бусад баримт бичгийн төсөл боловсруулж оруулах, оруулсан төслийг өөрчлөх;

- 7) Улсын Бага Хурлаас байгуулах байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, мөн сонгох, томлох, албан тушаалтны тухай санал, дүгнэлт гаргах;

- 8) Улсын Бага Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонголыг хэлэлцэх шаардлага тавих, тэдэнд итгэхгүй байгааг илэрхийлэн огцруулах санал оруулах.

3. Улсын Бага Хурлын гишүүн иргэд, хамт олонтой уулзалт хийх, улс орны чанартай хурал, зөвлөлтөөн, цуглаанд эролцож үзэл бодлоо илэрхийлэх, мөн аль ч байгууллагад Улсын Бага Хурлын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар чөлөөтэй нэвтэрч, хүлээгдээгүй уулзах эрхтэй.

4. Улсын Бага Хурлын гишүүн ямар ч байгууллага, албан тушаалтанд асуулт, асуулга тавих эрхтэй бөгөөд тэдгээрийн хариуг 30 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардаж улмаар шаардлагатай гэж үзвэл асуулга, түүний хариуг Улсын Бага Хурлын чуулган, холбогдох байнгын хорооны хуралдаанд сонордуулж хэрхэхийг шийдвэрлүүнэ. Асуултын хариуг амаар буюу бичгээр өгнө.

Улсын Бага Хурлын гишүүний тавьсан асуулга, асуултын талаар гарсан маргааныг Улсын Бага Хурал эцэслэн шийдвэрлэнэ.

5. Улсын Бага Хурлын гишүүн иргэд, хамт олноос ирүүлэн санал, хүсэлтийг Улсын Бага Хурлын чуулган, байнгын хорооны хуралдаанд сонордуулж хэрхэхийг шийдвэрлүүнэ.

Мөн уг санал, хүсэлттэй танилцахыг холбогдох төр, олон нийтийн байгууллагын удирдах албан тушаалтнаас хүсч болно. Ийнхүү хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан түүний өгтөөсөн хугацаанд хянан үзэж харну өгөөгүй бол энэ тухай нхааруулж Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, на-

рийн бичгийн даргын хэн нэгэнд нь мэдэгдэнэ. Тухайн албан тушаалтан хүлээж авсан санал, хүсэлтийг БНМАУ-ын хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэж холбогдох иргэн, хамт олон болон Улсын Бага Хурлын гишүүнд мэдээлэх үүрэгтэй.

6. Улсын Бага Хурлын гишүүн нь орон нутгийн Ардын Хурлын чуулган, тэдгээрийн байгууллагын хуралдаан, үзлэг, шалгалтад оролцох, шаардлагатай гэж үзвэл зохих сонирхогчдыг оролцуулан хяналт шалгалуу санаачлан явуулах эрхтэй. Хяналт шалгалтын үр дүнгийн талаар холбогдох байнгын хороонд мэдээлж зохих арга хэмжээ авахуулна.

7. Улсын Бага Хурал эрх хэмжээнийхээ хүрээнд гишүүндээ нэмэгдэл эрх олгож болно.

### 21 дүгээр зүйл. Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрхийн баталгаа

1. Улсын Бага Хурлын гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төр, олон нийтийн байгууллага, үйлдвэрийн газар, байгууллага, тэдгээрийн албан тушаалтан бүх талын туслаацаа үзүүлэх үүрэгтэй.

2. Улсын Бага Хурлын гишүүнийг Улсын Бага Хурлын зөвшөөрөлгүйгээр (түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуцаагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, түүний гэр, албан тасалгаа, биед нь нэгжлэг, үзлэг хийхийг хориглоно.

3. Улсын Бага Хурал тухайн гишүүнийхээ халдашгүй дархан эрхийг хөндөх тухай мэдэгдэл хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор албан ёсны хариу өгөөгүй бол холбогдох байгууллага, албан тушаалтан дээрх арга хэмжээг авах эрдтэй. Улсын Бага Хурлын гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Улсын Бага Хурлын даргад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

4. Улсын Бага Хурлын гишүүн нь гадаадад байх, зорчих хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.

5. Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа явуулахтай холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

6. Улсын Бага Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын албан татвараас бусад албан дайчлалгаа, цэргийн элжит татлагаас чөлөөлөгдөнө.

7. Улсын Бага Хурлын гишүүний цалингийн хэмжээг БНМАУ-ын Ардын Их Хурал тогтооно.

8. Улсын Бага Хурлын гишүүний албан тушаалд ажилла-сан хугацааг улсад ажиллаасан нийт бэлэн сонгогдохын өмнө ажиллаж байсан мэргэжлээрээ ажилласан хугацаанд оруулан тооцно.

9. Улсын Бага Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон буюу энэ хуулийн 6 дугаар зүйлийн 3, 19 дүгээр зүйлийн 2-ын 2-т заасан тохиолдолд түүнийг хуучин ажилд нь эгүүлэн ажиллуулах буюу тухайн ажил байхгүй бол өөрийн нь зөвшөөрснөөр ямар ч байгууллагад урьд авч байсан цалин хөлс нь буурахааргүйгээр ажил олгоно.

10. Улсын Бага Хурлын гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд «БНМАУ-ын Бага Хурлын гишүүн» гэсэн үнэмлэх, төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Улсын Бага Хурлын гишүүний үнэмлэх, хэвлэмэл хуудасны загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Улсын Бага Хурал батална.

22 дугаар зүйл. Улсын Бага Хурлын гишүүний журамт үүрэг, хариуцлага

1. Улсын Бага Хурлын гишүүн нь БНМАУ-ын хууль тогтоомж, төр, ард түмний бүрэн эрхт төлөөлөгчийн баримтлах зан суртахуун, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих үүрэгтэй. Хэрэв Улсын Бага Хурлын гишүүн энэ үүргээ зөрчвөл, мөн бүрэн эрхээ хэтрүүлбэл тухайн асуудлыг байнгын хороо буюу Улсын Бага Хурлын даргын хүсэлт эсвэл гишүүдийн олонхийн шаардлагаар Улсын Бага Хурал хянан хялацуж дор дурдсан хариуцлагын арга хэмжээг хүлээлгэнэ:

1) анхааруулах;

2) буруушаах;

3) гишүүнээс огцруулах саналыг БНМАУ-ын Ардын Их Хуралд тавих.

2. Улсын Бага Хурлын гишүүн чуулган дээр хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө хуулийн хариуцлага хүлээхгүй.

3. Улсын Бага Хурлын гишүүн нь өөрт итгэмжлэн мэдэгдсэн улсын болон албаны нууцыг чанд хамгаалах үүрэгтэй бөгөөд тэдгээрийг хувийн хонжоо олох зорилгоор ашиглахыг хориглоно.

4. Улсын Бага Хурлын гишүүд албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өгсөн 500 төгрөгнөөс дээш үнэтэй бэлгийг Улсын Бага Хуралд танилцуулж байна. Уг бэлгийг хэрхэхийг Улсын Бага Хурал шийдвэрлэнэ.

5. Улсын Бага Хурал шаардлагатай гэж үзвэл гишүүнийхөө ватгээ, мэдээлэл, тайланг сонсож зохих шийдвэр гаргана.

23 дугаар зүйл. Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргын бүрэн эрх

1. Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн

даргын бүрэн эрх нь энэ хуулийн 19—22 дугаар зүйл, мөн БНМАУ-ын бусад хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

2. Улсын Бага Хурлын дарга нь Улсын Бага Хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг ерөнхийд нь удирдан зохион байгуулж, БНМАУ-ыг Улсын Бага Хурлын эрх хэмжээний хүрээнд дотоод, гадаадад төлөөлнө.

Улсын Бага Хурлын орлогч дарга нь Улсын Бага Хурлын даргын эзгүйд үүргийг нь гүйцэтгэхээс гадна Улсын Бага Хураал, түүний даргаас даалгасан бусад ажлыг эрхэлнэ.

Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга нь Улсын Бага Хурлын дотоод зохион байгуулаалтын ажил, аппаратын өдөр тутмын ажлыг удирдана.

3. Улсын Бага Хурлын дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргана.

4. Улсын Бага Хурлын даргын орон сууц, түүний зардал үйлчилгээг уас хариуцна. Улсын Бага Хурлын дарга уналгаар хангагдана.

Улсын Бага Хурлын даргын бие, бүрэн эрх, нэр төр, алдар хүнд, орон сууц, уналга халдашгүй дархан байна. Улсын Бага Хурлын дарга улсын хамгаалаалтад байна. Улсын Бага Хурлын даргын биеийн эрүүл мэндийг онцлон хамгаална.

Улсын Бага Хурлын дарга бүрэн эрхийн хугацаа дууссанаас эхлэн нэгэн бүрэн эрхийн хугацаанд Улсын Бага Хурлаас тогтоосон хангамж өдэлж, улсын хамгаалаалтад байна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

*БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр болох, тэдгээрийг нийтлэх журам*

24 дүгээр зүйл. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэр хүчин төгөлдөр болох хугацаа

1. БНМАУ-ын хуулийг батламжаагдсанаас нь, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийг батлагдсанаас нь хойш Улсын Бага Хурлын нарийн бичгийн дарга зөвшөөрснөөр 3 хоногийн дотор «Ардын эрх» сонинд нийтэлнэ.

2. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэр нь тэдгээрт тухайлсан хугацаа заагаагүй бол «Ардын эрх» сонинд нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

25 дугаар зүйл. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийг нийтлэх

1. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийн эхийг Улсын Бага Хурлын Тамгын газар эрхлэн «Төрийн мэдээлэл» сэтгүүлд болон «Ардын эрх» сонинд нийтлэхээс гадна товхимол болгон хэвлүүлж болно. Эдгээрийг БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийн албан ёсны эх сурвалж болгон хэрэглэнэ.

2. БНМАУ-ын хууль, Улсын Бага Хурлын бусад шийдвэрийг төв, орон нутгийн бусад сонин, хэвлэлд нийтлэх, радио, телевизээр дамжуулахдаа «Төрийн мэдээлэл» сэтгүүл, «Ардын эрх» сонинд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтлах бөгөөд ийнхүү дамжуулан нийтэлснийг албан ёсны бус гэж үзнэ.

3. Улсын Бага Хурлын чуулганы явц, үр дүнгийн тухай олон нийтэд зориулсан албан ёсны мэдээллийг зөвхөн Улсын Бага Хурлын итгэмжлэгдсэн сурвалжлагч буюу хэвлэлийн төлөөлөгч хариуцан нийтлүүнэ.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

26 дугаар зүйл. Улсын Бага Хурлын төсвийг зарцуулах, тайлагнах

1. Улсын Бага Хурал, түүний аппаратын зардлыг БНМАУ-ын төсвөөс санхүүжүүлнэ. Түүнийг нэгтгэн зохицуулж зарцуулах асуудлыг Улсын Бага Хурлын дарга эрхлэн хэрэгжүүлнэ.

2. Улсын Бага Хурлын жил бүрийн зардлын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг Улсын Бага Хурлын чуулган батална.

27 дугаар зүйл. Улсын Бага Хурлын ажлын аппарат

1. Улсын Бага Хурлын ажлын аппарат нь Улсын Бага Хурлын Тамгын газар мөн. Улсын Бага Хурлын Тамгын газрын бүтэц, орон тоо, дүрмийг Улсын Бага Хурлын дарга батална.

2. Улсын Бага Хурлын Тамгын газар нь БНМАУ-ын Ардын Их Хурал, түүний депутат, байнгын комисс, Монголын парламентын бүлгэмд нэгэн адла үйлчилнэ.

28 дугаар зүйл. Улсын Бага Хурлын тамга, тэмдэгт хэвлэмэл хуудас



1. Улсын Бага Хурал нь тогтоосон журмаар үйлдсэн БНМАУ-ын төрийн сүлд бүхний тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2. Улсын Бага Хурлын байнгын хороо нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нарийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 1 дүгээр  
сарны 15-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Засгийн газрын тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийг тус тус зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Засгийн газар-төрийн гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага

1. БНМАУ-ын Засгийн газар (цаашид «Засгийн газар» гэх) нь БНМАУ-ын төрийн гүйцэтгэн захирамжлах дээд байгууллага мөн.

2. Засгийн газар БНМАУ-ын хууль, БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хурлын бусад шийдвэр, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг биелүүлэх үндсэн дээр аж ахуй, нийгэм-соёлын байгуулалт, захиргааны үйл ажиллагааг удирдана.

3. БНМАУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

2 дугаар зүйл. Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчим

1. Засгийн газар нь эх орныхоо тусгаар тогтнол, ард түмнийхээ ашиг сонирхол, эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, хүний эрхийг хүндэтгэж ажиллана.

2. Засгийн газар нь дэлхийн улс орнуудтай эрх тэгш, харилцан үр ашигтай хамтын ажиллагаа, найрсаг харилцаа хөгжүүлэхэд БНМАУ-ын гадаад бодлогыг чиглүүнэ.

Засгийн газар үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хамтын харилцаагаа хүлээх, шинжлэх ухааны үндэслэлийг баримтлах зарчмыг удирдлага болгоно.

4. Засгийн газар улсын хөгжлийн нийтлэг асуудлыг шийдвэрлэхдээ орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд хөгжлийнхөө асуудлыг бие даан шийдвэрлэх, ажлынхаа үр дүнг өөрөө харуулах зарчмыг иш үндэс болгоно.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

*Засгийн газрын амхлан байгуулах, Засгийн газраас төрийн эрх барих дээд байгууллагуудтай харилцах*

*3 дугаар зүйл. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн*

1. Засгийн газрын бүтцийг БНМАУ-ын хуулиар тогтооно.
2. Засгийн газар нь Засгийн газрын гишүүдээс бүрдэнэ.

Засгийн газрын гишүүдийн бүрэлдэхүүнд БНМАУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын Тэргүүн шадар сайд, Шадар сайд нар, БНМАУ-ын сайд нар орно.

*4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэлдэхүүнийг батлах*

1. БНМАУ-ын Ерөнхий сайд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай саналаа БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлнэ. БНМАУ-ын Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэн нэр дэвшигчдийг БНМАУ-ын Бага Хурал хүн нэг бүр дээр хэлээгээж, олонхийн саналаар Засгийн газрын гишүүнээр томилно.

2. БНМАУ-ын Ерөнхий сайд томилогдсон өдрөөсөө эхлэн 30 хоногт багтаан Засгийн газрын бүрэлдэхүүнийг бүрдүүлнэ.

3. БНМАУ-ын Бага Хурал нь БНМАУ-ын Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр БНМАУ-ын төрийн захиргааны зарим удирдах албан тушаалтныг Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулж болно.

*5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа*

1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 5 жил байна.

2. Засгийн газрын бүрэн эрх нь түүний бүрэлдэхүүнийг БНМАУ-ын Бага Хурал баталсан өдрөөс эхэлж, шинээр байгуулсан Засгийн газрын бүрэлдэхүүнийг БНМАУ-ын Бага Хурлаас баталсан өдөр дуусгавар болно.

*6 дугаар зүйл. Засгийн газар огцрох тухайгаа өргөн мэдүүлэх*

1. БНМАУ-ын Бага Хуралд оруулсан Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэл, БНМАУ-ын хуулийн төсөл, бусад чухал асуудлын талаар БНМАУ-ын Бага Хурал зарчмын өөр саналтай бөгөөд энэ саналын дагуу гарах шийдвэрийг гэрэгжүүлэх явдлыг хангах боломжгүй буюу уг шийдвэрийн талаар харууллага хүлээж чадахгүй гэж үзсэн, эсхүл БНМАУ-ын Бага Хурал итгэл хүлээлгэхгүй болсон тохиолдолд Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааг дуусахаас өмнө огцрох тухайгаа БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлж болно.

2. БНМАУ-ын Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.

3. Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорч байгаа бол Засгийн газрын дэргэдэх тусгай газрын дарга нарыг тухайн албан тушаалд ажиллуулах эсэх тухай асуудлыг шинээр байгуулагдах Засгийн газар шийдвэрлэнэ.

7 дугаар зүйл. Засгийн газар итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг хүсэх

Засгийн газар итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг БНМАУ-ын Бага Хурлаас хүсэж болно. Хэрэв БНМАУ-ын Бага Хурал нь Засгийн газарт итгэхгүй байгаагаа илэрхийлсэн бол Засгийн газар огцрох тухайгаа БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүнэ.

8 дугаар зүйл. БНМАУ-ын Ерөнхий сайдын цалин, хангамж, хамгаалалт, Засгийн газрын бусад гишүүний цалин, хангамж

1. БНМАУ-ын Ерөнхий сайдын цалинг БНМАУ-ын Ардын Их Хурлаас тогтооно.

БНМАУ-ын Ерөнхий сайдын орон сууц, түүний зардал, үйлчилгээг улс хариуцна. БНМАУ-ын Ерөнхий сайд уналгаар хангагдана.

БНМАУ-ын Ерөнхий сайдын бие, бүрэн эрх, нэр төр, гадар хүнд, орон сууц, уналга хаалдашгүй дархан байна. БНМАУ-ын Ерөнхий сайд улсын хамгаалалтад байна. БНМАУ-ын Ерөнхий сайдын биеийн эрүүл мэндийг онцлон хамгаална.

БНМАУ-ын Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хугацаа дууссанаас эхлэн нэгэн бүрэн эрхийн хугацаанд БНМАУ-ын Бага Хурлаас тогтоосон хангамж эдэлж, улсын хамгаалалтад байна.

2. Засгийн газрын гишүүний цалин, хангамжийг БНМАУ-ын Бага Хурал тогтооно.

9 дүгээр зүйл. Засгийн газраас БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хуралтай харилцах

1. Засгийн газар үйл ажиллагааныхаа тухай БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хуралд мэдээлж байна.

2. Засгийн газар нь БНМАУ-ын хуулийн төсөл буюу нийтлэг ач холбогдолтой эрх зүйн бусад баримт бичгийн төслийг хэлэлцэх хугацааг өөрчлүүлэх тухай болон тодорхой асуудлыг авч үзэх хамтарсан комисс байгуулах, Засгийн газрын баримтаж байгаа байр суурийг танилцуулахын тулд холбогдох байнгын комисс буюу байнгын хорооны хуралдаан хийхийг

БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хуралд санал болгож болно.

3. Засгийн газар нь үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл, БНМАУ-ын хуулийн төсөл, бусад чухал асуудлаар БНМАУ-ын Бага Хурлынхаас зарчмын өөр саналтай байвал БНМАУ-ын Ерөнхий сайд уг асуудлыг дахин хэлэлцүүлэх саналыг БНМАУ-ын Бага Хуралд гаргаж болно.

4. БНМАУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд нь БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдаан, БНМАУ-ын Бага Хурлын чуулган, БНМАУ-ын Ардын Их Хурлын байнгын комисс, БНМАУ-ын Бага Хурлын байнгын хорооны хуралдаанд дээрх байгууллагуудын хүсэлтээр буюу асуудал оруулан хэлэлцүүлэх үед байцааж, үг хэлж болно.

*10 дугаар зүйл. Засгийн газраас БНМАУ-ын Ерөнхийлөгчтэй харилцах*

1. Засгийн газар энэ хуулийн 6, 7 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлж байгаа, итгэл хүлээж байгаа эсэхээ илэрхийлж өгөхийг БНМАУ-ын Бага Хурлаас хүсэж байгаагаа БНМАУ-ын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

2. Засгийн газар нь БНМАУ-аас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томлоох буюу эгүүлэн татах тухай саналыг БНМАУ-ын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэнэ.

3. Засгийн газар шаардлагатай бол ямар ч асуудлыг БНМАУ-ын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж болно.

4. БНМАУ-ын Ерөнхий сайд БНМАУ-ын Ерөнхийлөгчийг Засгийн газрын хуралдаанд урьж болно.

*11 дүгээр зүйл. Засгийн газар үйл ажиллагаагаа хариуцан тайлагнах*

1. Засгийн газар үйл ажиллагаагаа БНМАУ-ын Ардын Их Хурал, БНМАУ-ын Бага Хуралд хариуцан тайлагнаана.

2. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаанд явуулах үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийг хэлэлцүүлэхээр БНМАУ-ын Бага Хуралд бүрэн эрхээ эдэлж эхэлснээс хойш 60 хоногийн дотор өргөн мэдүүлэнэ.

3. Засгийн газар үйл ажиллагааныхаа тухай БНМАУ-ын Бага Хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнаж байна.

4. Засгийн газар, түүний гишүүн нь БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, БНМАУ-ын Бага Хурлын гишүүний асуулыг хариуг БНМАУ-ын хууль тогтоомжид заасан хугацаанд

БНМАУ-ын Ардын Их Хуралын хуралдаан, БНМАУ-ын Бага Хуралын чуулган дээр амаар буюу бичгээр өгөх үүрэгтэй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Засгийн газрын эрх хэмжээ*

*12 дугаар зүйл. Засгийн газрын эрх хэмжээний гайтлаг асуудал*

Засгийн газар БНМАУ-ын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ дотор дор дурдсан нийтлэг асуудлыг харьцууна:

1) аж ахуй, нийгэм-соёлын байгуулалт болон захиргааны үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

2) улсын үйлдвэрийн газар, байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах журмыг тогтоох;

3) төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын үүрэг зорилтыг болон зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоож, тэдгээр байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

4) төрийн удирдлагын боловсон хүчний бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

*13 дугаар зүйл. Засгийн газрын үндсэн бүрэн эрх*

Засгийн газар нь дор дурдсан бүрэн эрх эдвэнэ:

1) БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлийг БНМАУ-ын Ардын Их Хуралд, БНМАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө, улсын нэгдсэн төсөл, зээл, санхүүгийн төлөвлөгөөг жил бүр БНМАУ-ын Бага Хуралд оруулах, тэдгээрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

2) улсын хэмжээний болон салбар хоорондын, нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн нэн чухал асуудлаар цогцолбор арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

3) өмчийн төрөл, хэлбэрийг тэгш эрхтэй, чөлөөтэй хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн ноцлолыг бүрдүүлэх, төрийн өмчийг хамгаалах, үйлдвэрлэлийн харилцааг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

4) иргэдийн эрх, эрх чөлөөг баталгаатай болгох арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;

5) шинжлэх ухаан-техникийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, байгаль, орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах цогцолбор арга хэмжээ авах;

6) удирдлагын зохион байгуулаалтыг боловсронгуй болгох, салбар, нутаг дэвсгэрийн удирдлагын зохион байгуулаалтын бүтцийг оновчтой болгох;

7) улсын батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8) хууль ёсыг бэхжүүлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах, гэмт явдалтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

9) хууль санаачлах;

10) БНМАУ-аас гадаад улс, Засгийн газар хоорондын олон улсын байгууллаагатай улс төр, худаадаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техникийн зэрэг салбарт хамтын ажиллагаа хэрэгжүүлэх чиг бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг чиглүүлж удирдах;

11) бүрэн эрхийнхээ хэмжээнд БНМАУ-ыг гадаад орон, олон улсын байгууллаагад төлөөлж БНМАУ-ын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх арга хэмжээ авахын дээр Засгийн газар хоорондын олон улсын гэрээг баталж, цуцлах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

*Засгийн газраас төрийн захиргааны төв байгууллагыг удирдах, орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны үйл ажиллагааг чиглүүлэх*

14 дүгээр зүйл. Засгийн газраас яам, улсын хороо болон өөрийн дэргэдэх тусгай газрыг удирдах

1. Засгийн газар яам, улсын хороо болон өөрийн дэргэдэх тусгай газрын ажлыг удирдана.

2. Засгийн газар шаардлагатай тохиолдолд аж ахуй, нийгэм-соёлын байгуулаалт, захиргааны үйл ажиллагааг эрхлэх тусгай газруудыг өөрийн дэргэд байгуулж болно. Мөн тэдгээрийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

3. Засгийн газар яам, улсын хороо болон өөрийн дэргэдэх тусгай газрын дүрэм, тэдгээрийн удирдлагын орон тоо, сарын цаалигчийн санг батална.



4. Засгийн газар нь бүрэн эрхийнхээ хэмжээнд яам, улсын хороо, өөрийн дэргэдэх тусгай газрын удирдах албан тушаалтныг томилно.

5. Засгийн газрын дэргэдэх тусгай газрын дарга нь харнууцсан саалбарыг тэргүүлж, уг саалбарын хөгжил, ажил хэргийн байдал, үр дүнг Засгийн газрын өмнө бүрэн харнууцна.

*15 дугаар зүйл.* Засгийн газраас төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих

1. Засгийн газар, яам, улсын хороо, өөрийн дэргэдэх тусгай газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрээс үүрэг, зорилтоо хэрэгжүүлэх, эрхэлсэн асуудлаа бие даан шийдвэрлэх явдлыг хангах арга хэмжээ авна.

2. Төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэр нь БНМАУ-ын хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар тэдгээрийг өөрчлүүлэх буюу хүчингүй болгож болно.

3. Засгийн газар өөрийн томилсон албан тушаалтанд сахилгын арга хэмжээ оногдуулж болно.

*16 дугаар зүйл.* Засгийн газраас орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны үйл ажиллагааг чиглүүлэх

1. Аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны үйл ажиллагааг улс орны хөгжлийн нийтлэг асуудлаар нэгтгэн чиглүүнэ.

2. Аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа болон төрийн захиргааны төв байгууллагаас эрх хэмжээгээ хэрэгжүүлэх, орон нутаг, саалбарыг хөгжүүлэх зорилтыг биелүүлэхэд нь тэдгээрийн хоорондын харилцан ажиллагааг уялдуулна.

3. Аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны шийдвэр нь БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, захирамжид нийцээгүй бол Засгийн газар тэдгээрийг өөрчлүүлэх буюу хүчингүй болгож болно.

4. Засгийн газар аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны үлгэрчилсэн бүтэц, удирдлагын орон тоо, сарын цалингийн санг батална.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Засгийн газрын ажлын зохион байгуулалт*

*17 дугаар зүйл.* Засгийн газрын хуралдаан

1. Засгийн газрын ээлжит хуралдааныг долоо хоног тутам хийнэ. Засгийн газрын ээлжит бус хуралдааныг БНМАУ-ын Ерөнхий сайдын буюу Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс доошгүйн санал болгосноор хийнэ.

2. Засгийн газрын хуралдааныг түүний гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ирсэн бол хүчинтэйд тооцно.

3. Засгийн газрын хуралдааныг БНМАУ-ын Ерөнхий сайд, түүний эзгүйд Засгийн газрын Тэргүүн шадар сайд удирдана.

4. Засгийн газрын хуралдааны дэгийг Засгийн газар өөрөө тогтооно.

5. Засгийн газар хуралдааныгаа тухай олон түмэнд тогтмол мэдээлж байна.

*18 дугаар зүйл.* Төрийн захиргааны болон бусад байгууллагаас Засгийн газарт асуудал оруулах

1. Яам, улсын хороо, Засгийн газрын дэргэдэх тусгай газар, төрийн зохих удирдлагыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий бусад байгууллага, аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа Засгийн газарт асуудал оруулна.

2. Төрийн захиргааны энэ зүйлийн 1-д зааснаас бусад байгууллага нь зохих яам, улсын хороо, тусгай газар, төрийн удирдлагын зохих үүргийг улсын хэмжээнд хэрэгжүүлдэг бусад байгууллага болон аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаагаар уламжлан Засгийн газарт асуудал оруулж болно.

3. Байгууллага, иргэд нь Засгийн газрын шийдвэр гаргуулах шаардлагатай асуудлаа БНМАУ-ын холбогдох сайд, улсын хорооны дарга, Засгийн газрын дэргэдэх тусгай газрын дарга, аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаагаар уламжлан Засгийн газарт оруулж болно.

*19 дүгээр зүйл.* Засгийн газрын тогтоол

1. Засгийн газар байнга дагаж мөрдөх буюу улс орны нэн чухал, нийтлэг ач холбогдолтой асуудлаар тогтоол гаргана. Засгийн газрын тогтоол БНМАУ-ын Ерөнхий сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гарын үсэг зурна.

2. Засгийн газрын тогтоолыг «БНМАУ-ын Засгийн газрын шийдвэр»-ийн эмхтгээд нийтэлнэ. Засгийн газрын тогтоолыг цаг тухайд нь олон түмэнд мэдээлэх шаардлагатай бол хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

3. Засгийн газрын тогтоол нь тусгайлан хугацаа заагаагүй бол гаргасан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

*20 дугаар зүйл.* БНМАУ-ын Ерөнхий сайдын бүрэн эрх

1. БНМАУ-ын Ерөнхий сайд дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

1) Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай саналаа БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлэх;

2) Засгийн газрыг тэргүүлж үйл ажиллагааг нь зохион байгуулж, чиглүүлэн удирдах;

3) Засгийн газрын хуралдааныг товлож, удирдах. Засгийн газрын ээлжит бус хуралдаан хийх санал оруулах;

4) Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, нөхөн томилуулах тухай саналыг БНМАУ-ын Бага Хуралд өргөн мэдүүлэх;

5) Засгийн газрын бүрэн эрхийн хэмжээнд олон улсын харилцаанд БНМАУ-ыг төлөөлөх;

6) Засгийн газрын гишүүний огцрох тухай хүсэлтийг хүлээн авах;

7) цаг үеийн болон шуурхай асуудлаар захирамж гаргах.

2. БНМАУ-ын Ерөнхий сайдын эзгүйд түүний үүргийг Засгийн газрын Тэргүүн шадар сайд хэрэгжүүлнэ.

3. БНМАУ-ын Ерөнхий сайд биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзвэл уг албан тушаалаас чөлөөлж өгөх хүсэлтээ БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдааны үед БНМАУ-ын Ерөнхийлөгчид, БНМАУ-ын Ардын Их Хурлын чөлөө цагт БНМАУ-ын Бага Хуралд гаргаж болно. БНМАУ-ын шинэ Ерөнхий сайдыг томилогдтол БНМАУ-ын Ерөнхий сайдын бүрэн эрхийг Засгийн газрын Тэргүүн шадар сайд хэрэгжүүлнэ.

4. БНМАУ-ын Ерөнхий сайд чөлөөлөгдсөн тохиолдолд шинээр томилогдсон БНМАУ-ын Ерөнхий сайд Засгийн газрын гишүүдтэй ажиллах эсэхээ өөрөө шийднэ.

## *21 дүгээр зүйл. Засгийн газрын гишүүд*

1. Засгийн газрын гишүүд нь өөрийн хариуцсан салбар төдийгүй Засгийн газрын нийт үйл ажиллагааны талаар хариуцлага хүлээнэ.

2. Засгийн газрын гишүүд хуралдаандаа таслах эрхтэйгээр биечлэн оролдож, БНМАУ-ын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын төсөл санаачлан боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулна.

3. Засгийн газрын гишүүд албан тушаалаасаа огцрох тухай хүсэлтээ БНМАУ-ын Ерөнхий сайдад хэдийд ч гаргаж болно.

4. Засгийн газрын Тэргүүн шадар сайд, Шадар сайд нар нь аж ахуй, нийгэм, соёл, захиргаа-улс төрийн байгуулалтын хариуцсан чиглэлийнхээ үйл ажиллагааг зохицуулж, тухайн салбарыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх болон бусад асуудлаар шуурхай заалт өгөх буюу БНМАУ-ын Ерөнхий сайдын

нэрийн өмнөөс шийдвэр гаргаж, тодорхой асуудлаар өөрийн хувиалбарыг боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж болно.

Засгийн газарт оруулж байгаа БНМАУ-ын хууль, Засгийн газрын шийдвэрийн төсөл, саналыг урьдчилан хянан үзнэ.

5. БНМАУ-ын сайд нар нь хариуцсан салбарыг Засгийн газрын өмнөөс удирдаж, уг салбарын хөгжил, ажил хэргийн байдал үр дүнг Засгийн газрын нэрийн өмнөөс бүрэн хариуцна.

БНМАУ-ын сайд үүргээ хэрэгжүүлэхээр эрх хэмжээнийхээ дотор дангаараа буюу хамтран тушаал гаргаж, үүрэг даалгавар, зөвлөлдгөө огч биелэлтийг нь хангуулна. БНМАУ-ын сайдын тушаал, өгсөн үүрэг, даалгаврыг холбогдох яам, улсын хороо, Засгийн газрын дэргэдэх тусгай газар, орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, үйлдвэрийн газар, байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

6. Засгийн газрын гишүүдийг БНМАУ-ын Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр (түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчласнаас бусад тохиолдолд) эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, тэдэнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, тэдний гэр, албан тасалгаа, биед нь нэгжлэг, үзлэг хийхийг хориглоно.

Засгийн газрын гишүүд нь гадаадад байх, зорчих хугацаандаа дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ.

*22 дугаар зүйл. Засгийн газрын ажлын байгууллага*

Засгийн газар шаардлагатай гэж үзвэл түр буюу байнгын зөвлөл, ажлын бусад байгууллагыг байгуулж болно.

*23 дугаар зүйл. Засгийн газрын ажлын аппарат*

Засгийн газрын ажлын аппарат нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар мөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын бүтэц, цалингийн сан, түрмийг Засгийн газар батална.

*24 дүгээр зүйл. Засгийн газар, түүний аппаратад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглох*

Засгийн газар, түүний аппаратад нам, олон нийтийн байгууллагын шугамаар улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

25 дугаар зүйл. Засгийн газрын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

Засгийн газар нь тогтоосон журмаар үйлдсэн БНМАУ-ын төрийн сүлд бүхий тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

1991 оны 1 дүгээр  
сарын 04-ний өдөр

Улаанбаатар  
хот

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ

1991 оны 1 дүгээр  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

«БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тухай хуулийг батлах тухай» 1983 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн БНМАУ-ын хуулийг БНМАУ-ын Засгийн газрын тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ**

1991 оны 1 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар 6

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ**

БНМАУ-ын Бага Хурлаас баталсан БНМАУ-ын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг зөвшөөрөн батламжласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

БҮГД НАЯРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ХУУЛЬ

1990 оны 12 дугаар  
сарны 28-ны өдөр

Улаанбаатар  
хот

БНМАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

БНМАУ зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбогдуулан Эрүүгийн хуулиар өмчийн олон хэлбэрийн адил тэгш байдлыг хангах зорилтыг удирдлага болгон БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг, 5 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 дүгээр зүйлийн нэг дэх хэсэг:

«1. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн зорилт нь БНМАУ-ын төр, нийгэм-эдийн засгийн байгууламж, иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх, эрх чөлөө, хувийн болон нийтийн өмч, түүнчлэн эрх зүйн журмыг гэмт халдлагаас хамгаалахад оршино»;

5 дугаар зүйлийн нэг дэх хэсэг:

«1. БНМАУ-ын төр, нийгэм-эдийн засгийн байгууламж, иргэдийн амь бие, эрүүл мэнд, улс төр, хөдөлмөрийн болон бусад эрх, эрх чөлөө, хувийн болон нийтийн өмч, түүнчлэн эрх зүйн журамд халдсан бөгөөд Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюультай хэрэг (үйлдэл, эс үйлдэл)-ийг гэмт хэрэг гэж үзнэ».

2. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн гурав, тав-дугаар бүлэгт заасан зүйлүүдийг нэгтгэж, тусгай ангийн гурав-дугаар бүлгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Өмчийн эсрэг гэмт хэрэг*

123 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлж ашиглан  
шамшигдуулах



1. Бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Бусдад үлэмж хэмжээтэй хохирол учруулсан, нийтэд учирсан гамшигт байдлыг даалмдуулж буюу машин механизм ашиглаж, эсхүл орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Ону аюультай рецидив гэмт хэрэгтэн буюу их хэмжээтэй хулгайлсан бол нутаг заах буюу заахгүйгээр, эд хөрөнгийг хурааж таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ хуулийн 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан давтан гэдэг нь урьд эдгээр зүйл буюу 73, 125, 130, 245 дугаар зүйлд заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэний дараа 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэнийг хэлнэ.

*124 дүгээр зүйл.* Бусдын эд хөрөнгийг булааж ашиглан шамшигдуулах

1. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр булаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Бусдын амь бие, эрүү мэндэд аюулгүйгээр хүч хэрэглэж буюу давтан, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг этгээд булаасан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

3. Бусдад үлэмж хэмжээтэй хохирол учруулсан буюу орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч булаасан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Ону аюультай рецидив гэмт хэрэгтэн буюу их хэмжээтэй булаасан бол нутаг заах буюу заахгүйгээр эд хөрөнгийг хурааж зургаагаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*125 дугаар зүйл.* Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх

1. Бусдын эд хөрөнгийг авах зорилгоор иргэдийн амь бие,

эрүүа мэндэд аюулайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг урьд бусдын эд хөрөнгийг авах зорилгоор дээрэмдсэн, зандалчилсан гэмт хэрэг үйлдсэн этгээд буюу онц аюулайт рецидив гэмт хэрэгтэн, эсхүл урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, түүнчлэн орон байр, агуулах саванд хууль бусаар нэвтэрч хийсэн, уг үйлдлийг хийхдээ зэвсэг буюу бусад зүйлийг зэвсгийн чанартайгаар хэрэглэсэн, эсхүл уг үйлдлийн улмаас иргэдийн бие махбодид хүнд гэмтэл учирсан буюу уг үйлдэл нь бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй авахад чиглэсэн бол нутаг заах буюу заахгүйгээр эд хөрөнгийг хурааж найман арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*126 дугаар зүйл.* Бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлж, эсхүл албан тушаалынхаа байдлыг урвуулаж ашиглан шамшигдуулах

1. Бусдын эд хөрөнгийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд уг эд хөрөнгийг завшсан буюу үрэгдүүлсэн, эсхүл албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг урвуулаж ашиглан шунахай зорилгоор бусдын эд хөрөнгийг авсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн зуугаас дөрвөн мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр, эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр долоон жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянгаас таван мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр, эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр таван арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*127 дугаар зүйл.* Бусдын эд хөрөнгийг заалиан мэхэлж ашиглан шамшигдуулах

1. Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдын эд хөрөнгийг авсан буюу түүнийг эзэмших эрхийг олж авсан бол

гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл дөрвөн зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянгаас гурван мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3. Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан буюу уг үйлдлийг онц аюультай рецидив гэмт хэрэгтэн хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр тавиас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*128 дугаар зүйл\*.*

*129 дүгээр зүйл.* Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдад эд хөрөнгийн хохирол учруулах

Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх замаар бусдад эд хөрөнгийн хохирол учруулсан нь ашиглан шамшигдуулсан шинжгүй бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, нэг мянга хүртэл төгрөгөөр торгох буюу хоёр жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ял шийтгэх, эсхүл олон шийтгийн нөлөөллийн арга хэмжээ авахуулна.

*130 дугаар зүйл.* Бусдын эд хөрөнгийг эвчээр далайлан сүрдүүлэх

1. Өмчлөгч, итгэмжлэгдэн хариуцаж буюу хамгаалж байгаа этгээдэд болон түүний ойр дотны хүмүүст хүч хэрэглэх, тэднийг гутаасан мэдээ баримтыг тараах буюу эд хөрөнгийг нь устгахаар занаалхийлж бусдын эд хөрөнгийг буюу уг эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн өгөхийг шаардсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл таван зуугаас хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, эсхүл онц аюультай рецидив гэмт хэрэгтэн хийсэн бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жилээс нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил

\* Энэ хуулиар хассан

хийлгэх, эсхүл нэг мянгаас дөрвөн мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*131 дүгээр зүйл.* Бусдын эд хөрөнгийг бага хэмжээтэй ашиглан шамшигдуулах

1. Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, булаах, далайлан сүрдүүлэхээс бусад аргаар бага хэмжээтэй ашиглан шамшигдуулсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд, эсхүл бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулсан (123—127 дугаар зүйл) гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*132 дугаар зүйл.* Тээврийн хэрэгсэл, машин буюу механизмыг шунахай зорилгоор дур мэдэн ашиглах

1. Үйлдвэр, албан газар, байгууллагын тээврийн хэрэгсэл машин буюу механизмыг шунахай зорилгоор дур мэдэн ашигласан хэрэгт захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсаны дараа дахин тийм үйлдэл хийсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийн улмаас их хэмжээтэй хохирол учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

*133 дугаар зүйл.* Эрчим хүч ашиглах журам зөрчих

Цахилгааны болон дулааны эрчим хүчнийг шунахай зорилгоор дур мэдэн ашигласан, тэдгээрийг ахуйн хэрэгцээнд ашиглах журам зөрчсөн хэрэгт захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсаны дараа дахин тийм үйлдэл хийсэн, эсхүл бага бус гэм хор учруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

*134 дүгээр зүйл.* Бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтэвх

1. Бусдын эд хөрөнгийг санаатай устгасан, гэмтээсэн бол

нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг галдан шатаах буюу нийтэд аюултай бусад аргаар хийсэн, эсхүл уг үйлдлийн улмаас хүний амь хохирсон буюу их хэмжээтэй хохирол, эсхүл өөр хүнд хор уршиг учирсан бол хоёроос арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

135 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг болгоомжгүй устгах, гэмтээх

Бусдын эд хөрөнгийг болгоомжгүй устгасан, гэмтээснаас хүний амь хохирсон, эсхүл өөр хүнд хор уршиг учирсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

136 дугаар зүйл. Машин механизмыг хайр гамгүй ашиглах, хадгалах

1. Хөдөө аж ахуй, барилга, тээвэр болон улс ардын аж ахуйн бусад салбарт хэрэглэж байгаа машин, механизм, тоног төхөөрөмжийг хайр гамгүй ашигласан буюу зүй бус хадгалснаас эвдсэн, хэрэгцээгүй болгосон, эсхүл эдгээр машин, механизмыг тоногсон бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ хэргийг удаа дараа үйлдсэн, эсхүл уг хэргийн улмаас их хэмжээтэй хохирол учирсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

137 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хамгаалах явдалд хариуцлагагүй зандах

1. Бусдын эд хөрөнгийг хамгаалах үүрэг бүхий этгээд өөрийнхөө үүрэгт ажилд хариуцлагагүй хандсанаас уг эд хөрөнгө их хэмжээтэй үрэгдсэн, гэмтсэн буюу үгүй болсон нь албан тушаалын гэмт хэргийн шинжгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох, эсхүл олон нийтийн нөлөөллийн арга хэмжээ авахуулна.

2. Энэ хэргийн улмаас онц их хэмжээтэй хохирол учирсан бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.

Гээгдэл буюу санамсаргүй олдсон, хадгалуулсан болон бусад зорилгоор итгэмжлэн өгсөн үнэт зүйл, эд хөрөнгө, аадуул малыг бусдын эд хөрөнгө болохыг мэдсээр байгаад завшсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажла хийлгэх, эсхүл нэг мянга таван зуу хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

139 дүгээр зүйл. Гадаад улс, түүний байгууллага, иргэд, олон улсын байгууллагын өмчийн эсрэг гэмт хэрэг

БНМАУ-ын нутаг дэвсгэрт байгаа гадаад улсын байгууллага, иргэд, олон улсын байгууллагын өмчийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол энэ бүлгийн аль тохирох зүйлд зааснаар ял шийтгэнэ».

3. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а) 6 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт «улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг их хэмжээтэй буюу онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэг, 126 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 128 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг булаах (124 дүгээр зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг, 154 дүгээр зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг); улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх, (125, 155 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (134 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг, 160 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар иргэдийн амины эд хөрөнгийг хулгайлах (153 дугаар зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «бусдын эд хөрөнгийг их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэг, 126 дугаар зүйлийн гурав дахь хэсэг); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах (124 дүгээр зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг); бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйл); бусдын эд хөрөнгийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай устгах, гэмтээх (134 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг);»;

б) 9 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт «улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг хулгайлах (123, 153 дугаар зүйл); улс, хоршоолол, олон нийтийн болон иргэ-

дийн амины эд хөрөнгийг булаах (124, 154 дүгээр зүйл); улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125, 155 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (134 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг, 160 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «бусдын эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх (123, 124, 125 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (134 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг);»;

в) 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «а» заалтад «онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг булаах (124 дүгээр зүйлийн дөрөв дэх хэсэг, 154 дүгээр зүйлийн дөрөв дэх хэсэг); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 155 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг); улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «онц хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг булаах (124 дүгээр зүйлийн дөрөв дэх хэсэг); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);»;

г) 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «б» заалтад «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 126 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг, 127 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг, 128 дугаар зүйл); улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125, 155 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар иргэдийн амины эд хөрөнгийг хулгайлах, булаах, заллан мэхлэх (153 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг, 154 дүгээр зүйлийн хоёр, гурав дахь хэсэг, 157 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 126 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг, 127 дугаар зүйлийн хоёр, гурав дахь хэсэг); бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйл);»

д) 42 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 155 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);»;

е) 51 дүгээр зүйлийн «в» заалтад «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 155 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг); улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг дээрэмдэх замаар онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);»;

ж) 53 дугаар зүйлийн тав дахь хэсгийн «б» заалтад «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн болон иргэдийн амины эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 155 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг);»;

з) 199 дүгээр зүйлд «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн гурав, дөрөв дэх хэсэг, 125 дугаар зүйл, 126 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 127 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 128 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар иргэдийн эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, заалиан мэхлэх (153 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 154 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 155 дугаар зүйл, 157 дугаар зүйлийн гурав дахь хэсэг); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 126 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 127 дугаар зүйлийн гурав дахь хэсэг); бусдын эд хөрөнгийг дээрэмдэх (125 дугаар зүйл);»;

и) 200 дугаар зүйлд «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 125, 126, 127, 128 дугаар зүйл); хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар иргэдийн эд хөрөнгийг хулгайлах, булаах, дээрэмдэх, заалиан мэхлэх



(153 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 154 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 155 дугаар зүйл, 157 дугаар зүйлийн гурав дахь хэсэг); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах, дээрэмдэх (156 дугаар зүйл);» гэснийг «хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах (123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 125, 126, 127 дугаар зүйл):»;

к) 6 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг, 23 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн «а», «б» заалт, 40 дүгээр зүйлийн хоёр, зургаа дахь хэсэг, 42 дугаар зүйлийн гурав, тав, зургаа, долоо дахь хэсэг, 50 дугаар зүйлийн гурав дахь хэсэг, 51 дүгээр зүйлийн «в» заалт, 53 дугаар зүйлийн тав дахь хэсгийн «б» заалт, 199 дүгээр зүйл, 200 дугаар зүйл, 220 дугаар зүйл, 221 дүгээр зүйл, 222 дугаар зүйлд «цагдан сэргийлэх» гэснийг «цагдаагийн»;

л) зургадугаар бүлгийн «Социалист аж ахуйн эсрэг гэмт хэрэг» гэсэн гэрчгийг «Аж ахуйн эсрэг гэмт хэрэг» гэж тус тус өөрчилсүгэй.

4. Эрүүгийн хуулийн 73 дугаар зүйлд «олон нийтийн» гэсний дараа «болон хувийн» гэж нэмсүгэй.

5. Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн нэг дэх хэсгээс «улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах», 24 дүгээр зүйлийн гурав дахь хэсгийн «а» заалтаас «155», 50 дугаар зүйлийн зургаа дахь хэсгээс «улс, хоршоолол, олон нийтийн эд хөрөнгийг дээрэмдэхээс бусад замаар онц их хэмжээтэй ашиглан шамшигдуулах (128 дугаар зүйл); иргэдийн амины эд хөрөнгийг онц их хэмжээтэй хулгайлах, булаах (156 дугаар зүйл)», 64 дүгээр зүйлээс «улс, хоршоолол, олон нийтийн» гэснийг тус тус хассугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БАТЛАМЖ

1991 оны 1 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 7

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ БАТЛАМЖЛАХ ТУХАЙ

Олон улсын валютын сан, Шинэчлэл хөгжлийн олон улсын банк, Олон улсын санхүүгийн корпорац, Олон улсын хөгжлийн ассоциацид БНМАУ гишүүнээр элсэх тухай БНМАУ-ын хуулийг зөвшөөрөн батламжилсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Дэд Ерөнхийлөгч

Р. ГОНЧИГДОРЖ

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН, ШИНЭЧЛЭЛ ХӨГЖЛИЙН  
 ОЛОН УЛСЫН БАНК, ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН  
 КОРПОРАЦ, ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИД  
 БНМАУ ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ТУХАЙ БНМАУ-ЫН ХУУЛЬ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Засгийн газар нь Олон улсын валютын Сан (цаашид «Сан» гэх), Шинэчлэл хөгжлийн олон улсын Банк (цаашид «Банк» гэх), Олон улсын санхүүгийн Корпорац (цаашид «Корпорац» гэх), Олон улсын хөгжлийн Ассоциаци (цаашид «Ассоциаци» гэх)-ийн хэлэлцээр, талгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд (энэ хуулийн I, II, III, IV хавсралт) болон дээрх байгууллагуудад БНМАУ-ыг гишүүнээр элсүүлдэг тухай Захирагчдын Зөвлөлийн тогтоолын заалт, нөхцөл, Сангийн хэлэлцээрт оруулах гуравдмь нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч, БНМАУ-ын нэрийн өмнөөс Сан, Банк, Корпорац, Ассоциацид гишүүнээр элсэх бүрэн эрхийг энэ хуулиар эдэлнэ.

2 дүгээр зүйл. БНМАУ-ын Засгийн газрын нэрийн өмнөөс БНМАУ-ын Сангийн сайд Сан, Банк, Корпорац, Ассоциацийн хэлэлцээрүүдийг хүлээн зөвшөөрсөн батламж өгч, гишүүнээр элсэхэд шаардагдах бусад баримт бичгийг үйлдэн хэлэлцээрүүдийн ах хувьд гарын үсэг зурж зохих газарт нь хадгалуулна.

3 дүгээр зүйл. БНМАУ Санд гишүүнээр элссэнээр Зөвлөжүүлэх Тусгай Эрхийн Газрын үйл ажиллагаанд оролцох эрх эдлэх бөгөөд үүнтэй уялдаж БНМАУ-ын хүлээх үүргийг биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахаа тодорхойлон Зөвлөжүүлэх Тусгай Эрхийн Газрын үйл ажиллагаанд оролцох батламжийг БНМАУ-ын нэрийн өмнөөс Сангийн сайд гардуулж хадгалуулна.

4 дүгээр зүйл. Сан, Банк, Корпорац, Ассоциацийн хэлэлцээрүүдэд заасан журмын дагуу эдгээр байгууллагаас БНМАУ-ын нэрийн өмнөөс зөвд авах, өөр зохимжтой хэлбэрээр хөрөнгө авч ашиглах, авсан зээл, хөрөнгөө буцаан төлөх, БНМАУ-ыг дээрх байгууллагуудад гишүүнээр элсүүлэх тухай Захирагчдын Зөвлөлийн тогтоолд заасан хэмжээгээр эдгээр байгууллагад хувь хөрөнгө оруулах, Зөвлөжүүлэх Тусгай Эрхийн Газарт БНМАУ оролцохтой холбогдсон төлбөр хийх үүргийг БНМАУ-ын Сангийн яам хариуцан гүйцэтгэнэ.

БНМАУ Сан, Банк, Ассоциацид гишүүнээр элссэнээс үүдэн үнэт цаас (бусдад дамжуулах эрхгүй, хүүгүй) гаргах зайлшгүй тохиолдолд уг үнэт цаасыг эдгээр байгууллагуудын зохих хэлэлцээрүүдийн дагуу гаргах эрхийг Сангийн яам эдэлнэ.

5 дугаар зүйл. БНМАУ-ын Сангийн яам БНМАУ-ын нэрийн өмнөөс Сан, Банк, Корпорац, Ассоциацитай санхүүгийн болон ажла хэргийн талаар харилцагч байгууллаагын үүрэг гүйцэтгэнэ.

6 дугаар зүйл. БНМАУ-ын Сангийн яам Сан, Банкны хэлэлцээрүүдээр зөвшөөрөгдсөн ажла, гүйлгээний дагуу БНМАУ-д олгох, гуйвуулах мөнгийг хүлээн авах эрх эдэлнэ.

7 дугаар зүйл. БНМАУ-ын төв Банк нь Сан, Банк, Корпорац, Ассоциацийн эзэмшилд байгаа БНМАУ-ын валют, үнэт цаасныг хадгалах үүрэг хүлээнэ.

8 дугаар зүйл. Сан, Банк, Корпорац, Ассоциацийн дээрх хэлэлцээрүүд нь БНМАУ-ын нутаг дэвсгэрт бүрэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

9 дугаар зүйл. БНМАУ-ын Засгийн газар Сан, Банк, Корпорац, Ассоциацид Монголын талын захирагч, орлогч захирагчийг томилно.

10 дугаар зүйл. БНМАУ-ын Засгийн газар нь Сан, Банк, Корпорац, Ассоциацийн хэлэлцээрүүд болон БНМАУ-ыг гишүүнээр элсүүлэх тухай Захирагчдын Зөвлөлийн тогтоолоор хүлээсэн үүргээ биелүүж, энэ хуулийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд БНМАУ-ын хууль тогтоомжийн дагуу зохих заавар, журам гаргана.

11 дугаар зүйл. Энэ хуулийг БНМАУ-ын Ерөнхийлөгч батламжилсан өдрөөс дагаж мөрдөнө.

БНМАУ-ын Бага Хуралын  
орлогч дарга

К. ЗАРДЫХАН

БНМАУ-ын Бага Хуралын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар  
сарны 3-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар  
хот

ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

1. Улаанбаатар хотын харьяа «Баянтал» хороо байгуулсугай.
2. «Баянтал» хорооны нутаг дэвсгэрийн хилийн цэсийг хавсралтын ёсоор тогтоосугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

Хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ХАРЬЯА «БАЯНТАЛ»  
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЦЭС

Төмөр замын 621 дүгээр километрийн багана, Билгүүн толгой, Лүн нэгдүгээр шон, Лүн хоёрдугаар шон, Сүүлтөлгой, Төмөр замын 18 дугаар зөрлөг, Төмөр замын 621 дүгээр километрийн багана.

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1990 оны 12 дугаар

Дугаар 35

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

хот

**КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ**

**БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

1. 1964 оны 12 дугаар сарын 13-нд хүчин төгөлдөр болсон «Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн Конвенци», түүнд засвар оруулсан 1972 оны «Протокол»-д БНМАУ нэгдэн орсугай.

2. Энэ конвенцид нэгдэн орсон тухайгаа НҮБ-д зохих журмын дагуу мэдэгдэж, ийнхүү нэгдэн өрсноос үүдэн гарах үүргийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

**Р. ГОНЧИГДОРЖ**

БНМАУ-ын Бага Хурлын  
и-рийн бичгийн дарга

**Б. ЧИМИД**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ**

1990 оны 12 дугаар

Дугаар 36

Улаанбаатар

сарын 6-ны өдөр

хот

**БНМАУ-ЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:**

1. БНМАУ-ын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай хуулийг 1991 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ хууль батлагдсантай холбогдуулан одоо дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн актуудыг түүнтэй нийцүүлэх арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАВРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 37

Улаанбаатар  
хот

### БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1991 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Засгийн газраас оруулсан БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1991 онд хөгжүүлэх чиглэлийг үндсэнд нь зөвшөөрч, түүний үндсэн үзүүвэрийг 1 дүгээр хавсралтын ёсоор; улсын даалгавар, захиалга, лимитийн нийт хэмжээ болон улсын төвлөрсөн экспортод нийлүүлэх гол нэрийн бүтээгдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Засгийн газарт даалгах нь:

а) улсын захиалгаар барих барилга байгууламжийн жагсгалтыг батааж, улсын даалгавар, захиалгаар үйлдвэрлэж нийлүүлэх бүтээгдэхүүн, гүйцэтгэх ажил, үйлчилгээний хэмжээ, зарим нөөцийн лимит, нийгмийн хөгжлийн асуудлаар төлөвлөсөн үзүүлэлтийг аймаг, хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа, холбогдох яам, улсын хороо, тусгай газар, бие даасан үйлдвэр

рийн газар, нүүс, нэгтгэлд хүргүүлэн БНМАУ-ын эдийн засаг, нийгмийг 1991 онд хөгжүүлэх чиглэлийн бичлэгийг хангах арга хэмжээ авсугай;

б) улсын далагавар, захиаагыг бүрэн биелүүлэх эдийн засгийн сонирхлыг бий болгох арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

Улсын Бага Хурлын 1990 оны 37  
дугаар тогтоолын 1 дүгээр хэсгэлт

## БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1991 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

(тэрбум төгрөгөөр)

1. Үндэсний орлогын үйлдвэрлэл (зөрөгцүүлэх үнээр)	7,9
2. Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ (санхүүжилтийн бүх эх үүсвэрээр)	3,66
3. Ашиглаалтад оруулах үндсэн фонд	3,46
4. Хүн амын мөнгөн орлого	6,55
5. Улс, хөршөөллийн жижиглэн худалдаачаах бараа гүйлгээ	5,9
Үүнээс: хүн амд худалдах бараа гүйлгээ	5,3



УЛСЫН ДААЛГАВАР, ЗАХИАЛГА, ЛИМИТИЙН  
НИЙТ ХЭМЖЭЭ БОЛОН УЛСЫН ТӨВЛӨРСӨН  
ЭКСПОРТОД НИЙЛҮҮЛЭХ ГОЛ НЭРИЙН  
БҮТЭЭГДЭХҮҮН

	ХЭМЖЭЭ
<b>I. Улсын төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлэх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн</b>	
1. Дөрвөн төрлийн мал, амьдын жингээр мян. т	181,5
2. Гахайн мах мян. т	5,1
3. Адуу, мян. толгой	53,7
4. Цоцгийн тос, т	3335
5. Сүү, сая. л	52,2
6. Өндөг, сая. шир	33,7
7. Хонины ноос, т	19400
8. Тэмээний ноос, т	2300
9. Ямааны ноолуур, т	1410
10. Үр тариа, мян. т	593,6
11. Төмс, мян. т	74,2
12. Хүнсний ногоо, мян. т	23,6
<b>II. Улсын даалгавраар үйлдвэрлэх бүтээгдэхүүн</b>	
1. Бэлтгэж, тээвэрлэх мод (дээд хэмжээ) мян. м <sup>3</sup>	1182,0
2. Зүсмэл материал, мян. м <sup>3</sup>	465,0
3. Цемент, мян. т	570,0
<b>III. Улсын төвлөрсөн экспортод нийлүүлэх гол нэрийн бүтээгдэхүүн</b>	
1. Мал, амьдын жин, мян. т	20
2. Мах, нядалгааны жин, мян. т	20
3. Адуу, мян. толгой	35
4. Богийн өлөн, мян. гогцоо	3200
5. Ямааны ноолуур, т	500

1	2
6. Ямааны хялгас, т	910
7. Адууны хялгас, т	670
8. Тэмээний ноос, т	1800
9. Зэсийн бэлжмэл (35%), млн. т	350,5
10. Молибдений бэлжмэл (47%), т	3557
11. Жонш:	
— жоншим бэлжмэл, млн. т	120
— хайлуур жонш I—III зэрэг, млн. т	43
— хайлуур жонш IV зэрэг, млн. т	11
— зэргийн бус жонш, млн. т	319
12. Нүүрс, млн. т	400
13. Цемент, млн. т	110
14. Зүсмэл материал, млн. м <sup>3</sup>	60
15. Ямааны ноолуур, тэмээний ноосон сүлжмэл, хөнжил, сая ам. долл.	19,0
16. Хивс, млн. м <sup>2</sup>	1900
17. Хонинь угаасан ноос, т	2000
18. Самнасан ноолуур, т	250
19. Бөмбөг ноолуур, т	68
20. Шевро буюу ямааны арьс, млн. шир	500
21. Шерет буюу хонинь арьс, млн. шир	210
22. Савхин хувцас, эдлэл, сая ам. долл.	20,0
23. Үслэг эдлэл, сая ам. долл.	2,2
24. Нэхий эдлэл, сая ам. долл.	14,0
25. Алт, мөнгөн эдлэл, сая ам. долл.	1,5
26. Тарваганы арьс, млн. шир	225
27. Бугын цусан эвэр, кг	600
28. Бугын ясан эвэр, т	60
29. Ангийн үс, сая ам. долл.	0,7

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар

Дугаар 38

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

хот

БНМАУ-ЫН ТӨСВИЙН 1989 ОНЫ ГҮЙЦЭТ-  
ГЭЛИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

БНМАУ-ын төсвийн 1989 оны гүйцэтгэлийн тайланг орлого 6901578,7 мянган төгрөгөөр; зарлага 7062345,0 мянган төгрөгөөр баталсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар

Дугаар 39

Улаанбаатар

сарын 13-ны өдөр

хот

БНМАУ-ЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас **ТОГТООХ** нь:

1. БНМАУ-ын Албан татварын хуулийг 1991 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. БНМАУ-ын Албан татварын хууль батлагдсантай холбогдуулан дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн актуудыг түүнд нийцүүлэх арга хэмжээг 1990 онд багтаан авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

3. БНМАУ-ын Албан татварын хууль батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн хавсралтад дурдсан зарим зарлиг, зарлигийн заалтыг 1991 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
варийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БНМАУ-ын Бага Хурлын 1990 оны  
39 дүгээр тогтоолын хавсралт

## БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРИМ ЗАРЛИГ, ЗАРЛИГИЙН ЗААЛТ

1. «Улсын төсөвт хураалгах ашгийн шимтгэлийн тухай» 1958 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 207 дугаар зарлигийн 21-ээс бусад зүйл.

2. «Хот суурин газарт ашиглаж байгаа малын татварын тухай» 1959 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр зарлиг.

3. «Хот суурин газарт ашиглаж байгаа малын татварын тухай 89 дүгээр зарлигт өөрчлөлт оруулах тухай» 1963 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 99 дүгээр зарлиг.

4. «Мал бүхий иргэдээс хураах мал аж ахуйн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай» 1963 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 112 дугаар зарлиг.

5. «Гүйлгээний татварын хуульд зарим өөрчлөлт оруулах тухай» 1964 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 107 дугаар зарлиг.

6. «Газар дор ажилладаг уурхайчдыг ашиг орлогын татвараас уул уурхайн үйлдвэрийн ажилчин, албан хаагч, инженер, техникийн болон тахир дутуугийн группэд орогчдыг хот, суу-

рин газрын малын татвар буюу мал бүхий иргэдээс хураах мал аж ахуйн татвараас чөлөөлөх тухай» 1965 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 195 дугаар зарлигийн 2 дугаар заалт.

7. «Мал бүхий иргэдээс мах, ноос, сүү заавал нийлүүлэх хуулийг батаах тухай» 1978 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 92 дугаар зарлиг.

8. «Зарлигт өөрчлөлт оруулах тухай» 1981 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 23 дугаар зарлиг.

9. «Ашиг орлогын татварын тухай» 1988 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 53 дугаар зарлигийн 6-аас бусад зүйл.

10. «Хөдөө аж ахуйн нэгдлийн орлогоос хураах татварын тухай» 1989 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 203 дугаар зарлигийн 3-аас бусад заалт.

11. «Хөдөө аж ахуйн нэгдлээс бусад хоршооллын үйлдвэрийн газар, байгууллагын орлогоос хураах татварын тухай» 1989 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 204 дүгээр зарлигийн 8-аас бусад заалт.

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРАЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар  
сарын 15-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### СУМЫН НЭР ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумынхаа нэрийг сэргээх талаар хөдөлмөрчдийн гаргасан хүсэлтийг харгалзан Өвөрхангай аймгийн «Зүйл» сумыг «Есөн зүйл» сум гэж нэрлэсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан «Орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтад өөрчлөлт оруулах тухай» Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 129 дүгээр зарлигийн 1 дүгээр заалтын «Өвөрхангай аймагт» гэсэн хэсгээс «Зүйл» гэсэн үгнийг хассугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар

сарын 28-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар

хот

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛА-  
ГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлэлцээд БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийг үндэслэн БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг зөвшөөрсүгэй.

2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар БНМАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд саад учруулах, улсын худалдаанд гарч байгаа барааг дамлан худалдах, мөн зорилгоор нөөцлөх, бараа, материалыг хууль бусаар хил давуулах зэрэг хэрэглээ, хуваарилалтын тэнцвэрийг алдагдуулах зохисгүй үйлдлийг таслан зогсоох шийдвэртэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг БНМАУ-ын Засгийн газар, хууль хамгаалах байгууллагуудад даалгасугай.

3. БНМАУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн чиглэлд заасан зорилтыг тус тусын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх шуурхай арга хэмжээ авахыг орон нутгийн Ардын Хурлын байгууллагуудад даалгасугай.

4. Улс орныхоо улс төр, эдийн засгийн амьдралыг тогтворжуулах улс төр, нийгэм-сэтгэл зүйн тааламжтай уур амьсгалыг бүрдүүлэхэд тус дөхөм үзүүлж ажиллахыг бүх нам, хөдөлгөөн, олон нийтийн байгууллагад зөвлөсүгэй.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Р. ГОНЧИГДОРЖ

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1990 оны 12 дугаар

сарын 28-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар

хот

БНМАУ-ЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ  
МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн гурав, тавдугаар бүлэгт заасан гэмт хэргийн тухай зүйлүүдийг нэгтгэж өөрчилсөнтэй холбогдуулан 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн өмчийн эсрэг бүх төрлийн хэргийг шийдвэрлэхдээ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйлд заасан үндэслэлийг баримталж байсугай.

3. 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө «социалист өмчийн эсрэг» болон «иргэдийн амины өмчийн эсрэг» гэмт хэргэгт ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь БНМАУ-ын Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд зааснаар оногдуулж болох яамн дээд хэмжэвнээс хүнд байвал уг ялыг шүүхийн магадлагаар БНМАУ-ын Эрүүгийн хуулийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авсугай.

4. БНМАУ-ын Эрүүгийн шинэ хуулийн төслийг боловсруулж БНМАУ-ын Бага Хурлын III чуулганд оруулахыг БНМАУ-ын Засгийн газар, Дээд шүүх, Ерөнхий прокурорт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр

Дугаар 1

Улаанбаатар

сарын 4-ний өдөр

хот

ХУУЛИУДЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Бага Хурлын тухай хууль, БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тухай хууль, БНМАУ-ын Засгийн газрын тухай хуулийг тэдгээрийн албан ёсны эхийг «Ардын эрх» соннид нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөлөөр тогтоосугай.

2. БНМАУ-ын хууль тогтоомжийн холбогдох актыг эдгээр хуульд нийцүүлэх арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр

Дугаар 2

Улаанбаатар

арын 4-ний өдөр

хот

КОНВЕНЦ СОЕРХОН БАТЛАХ ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. «Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчи-



лан сэргийлэх арга хэмжээний тухай» 1970 оны конвенциг соёрхон баталсугай.

2. Энэхүү конвенцээс үүдэн гарах БНМАУ-ын үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН БАГА ХУРЛЫН ТОГТООЛ

1991 оны 1 дүгээр

Дугаар 4

Улаанбаатар

сарын 19-ний өдөр

хот

### ТӨРИЙН ТӨВ ХЭВЛЭЛИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Бага Хурлаас ТОГТООХ нь:

1. «Ардын эрх» сониньг БНМАУ-ын төрийн өдөр тутмын төв хэвлэл байхаар тогтоосугай.

Төрийн бодлого, үйл ажиллагааг мэдвэлэн тайлбарлах, иргэд санал бодлоо чөлөөтэй нлэрхийлэх индэр байх нь «Ардын эрх» сонинь үндсэн үүрэг гэж үзсүгэй.

2. «Ардын төр», «Үндэсний эдийн засаг» сэтгүүлийг «Ардын эрх» сонинь редакцияас эрхлэн гаргаж байсугай.

3. «Ардын эрх» сонинь ерөнхий эрхлэгчийг БНМАУ-ын Бага Хурлаас томилж байхаар тогтоосугай.

4. «Ардын эрх» сонинь редакцийн бүтэц, цалингийн сан зардлын төсвийг зохих журмын дагуу тогтоож түүнийг санхүүжүүлэх болон төрийн төв хэвлэлийн үйлдвэр байгуулах асуудлыг шийдвэрлэж өгөхийг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

5. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 42 дугаар тогтоолын 1, 3, 4, 5, 6; мөн 1990 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 65 дугаар тогтоолын 1, 2, 4 дүгээр заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

БНМАУ-ын Бага Хурлын  
дарга

Р. ГОНЧИГДОРЖ

БНМАУ-ын Бага Хурлын  
нэрийн бичгийн дарга

Б. ЧИМИД

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1990 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

**ЦЭРЭНГИЙН ГҮРБАДАМЫГ ЭЛЧИН САЙДЫН  
ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ**

Цэрэнгийн Гүрбадамыг БНМАУ-аас Бүгд Найрамдах Финланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1990 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар  
хот

**НЯМЫН МИШИГДОРЖИЙГ ЭЛЧИН САЙДААР  
ТОМИЛОХ ТУХАЙ**

Нямын Мишигдоржийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томиласугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1990 оны 12 дугаар  
сарын 14-ний өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

**ОРОН НУТГИЙН АРДЫН ХУРЛЫН СОНГУУЛЬ  
ЯВУУЛАХ ТУХАЙ**

Улаанбаатар хотын харьяа Байнтал хорооны Ардын Хурлын сонгуулийг 1991 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн Ням гаригт явуулсугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1990 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

**ЦАГДААГИЙН ТАНГАРАГ БАТЛАХ ТУХАЙ**

*Цагдаагийн тангариийг дор дурдсанаар баталсугай.*

**ЦАГДААГИЙН ТАНГАРАГ**

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын иргэн Би өөрийн хүсэлтээр цагдаагийн байгууллагад орж, төрийн төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэхдээ ард түмнийхээ аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахнуулахын төлөө бүхий л

мэдлэг чадвараа дайчлан ажиллаж, шаардлага гарвал амь биеэ үд хайрлахаа эх орон, ард түмэн, төр засагтаа батлан тангараглая.

Би цагдаагийн ажлын эрдэм ухаан, соёлд шамдан суралцаж, хүнлэг ёс, чин шударгыг эрхэмлэн, төрийн хуулиа дээдлэн сахиж биелүүлэхээ тангараглая.

Би энэ тангаргаасаа ицваас төрийн хуулийн цээрлэл хүлээнэ.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1990 оны 12 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

### ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ

1. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд төр, сүм хийдийн харилцааг зохицуулах алба байгуулж, дор дурдсан үндсэн үүрэгтэйгээр ажиллуулсугай:

а) төр засаг ба сүм хийд бие биений дотоод хэрэгт үл оролцох зарчим баримтлахын зэрэгцээ монголын ард түмний эв нэгдлийг хангах, уламжлалт соёл, зан заншлыг сэргээх, иргэдэд хүнлэг нигүүлсэнгүй үзэл хүмүүжил төлөвшүүлэх чиглэлээр хамтран ажиллаж, харилцан дэмжлэг үзүүлэх;

б) БНМАУ-ын иргэдийн аливаа шашныг шүтэх, эс шүтэх эрх чөлөөг тэгш эдлүүлэх, шашин хоорондын харилцааг зохицуулах, лам санваартны иргэний болон хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх хууль зүйн баталгааг хүний эрхийн нийтлэг хэм хэмжээнд нийцүүлэн боловсронгуй болгох талаар санаа, төсөл бэлтгэх, хууль зарлигийн биелэлтэд хяналт тавих;

в) төрөөс сүм хийдтэй харилцахад баримтлах бодлогын асуудлаар сүсэгтэн, санваартны эрх ашгийг хамгаалсан олон нийтийн байгууллага, сүм хийдтэй хамтран судалгаа хийж, санал зөвлөмж боловсруулах.

2. Уламжлалт зарим хийдийг сэргээн засварлах, барих, Өлгий хотод мечет байгуулах, музей, номын сангийн нөөцөд буй бурхан тахиа, ном судраас урлаг соёлын үнэт сан хөмрөгт үл хамаарах хэсгийг шилжүүлэх талаар сүсэгтэн, санваартны зүгээс гаргаж буй хүсэлтийг анхааран үзэж тусламж дэмжлэг үзүүлэхийг БНМАУ-ын Засгийн газарт даалгасугай.

3. Сүм хийдийн хурал мөргөлийн үйл ажиллагааг шинэчлэн сэргээхдээ өнөө эртний уламжлал, өнөө цагийн хэрэгцээг хослуулан шашныг дэвшилттэй жам ёсоор нь хөгжүүлэх, зохих бэлтгэл хийж шашны судар номыг эх хэлээрээ уншиж бясалгах, дотоод дүрэм, дульбаа жаягаа чанд баримтлан санваартны сахилга, дэг журам, эв эеийг бататгах, шашны нэр хүндийг ариун байлгах талаар бүр эхнээс нь хүчин зүтгэл гаргаж хичээнгүйлэн мөрдөхийг бүх сүм хийдийн хамба, лам, хуврагуудад зөвлөмж болгосугай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

## БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЯЛӨГЧИЙН ЗАРАЛГ

1990 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

## КОМИСС БАЙГУУЛАХ ТУХАЙ

1. Гуч, дөчөөд он, тавиад оны эхэн үед улс төрийн хилс сэрэгт татагдаж хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг үргэлжлүүлэн удаалж цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг дор дурдсан албан тушаалтны бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- Комиссын дарга — БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч  
Орологч дарга — БНМАУ-ын Засгийн газрын хэрэг  
эрхлэх газрын дарга  
Гишүүд — БНМАУ-ын Бага хурлын нарийн бич-  
гийн дарга  
— БНМАУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын  
газрын дарга  
— БНМАУ-ын Сангийн сайд  
— БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх  
Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий  
газрын дарга  
— Комиссын нарийн бичгийн дарга

2. Комисст даалах нь:

а) Улс төрийн хилс хэрэгт татагдаж «Онцгой бүрэн эрхт комисс», «Тусгай комисс» зэрэг шүүхийн биш байгууллагаар шийтгэгдсэн хүмүүсийн хэрэг, түүнд холбогдогсдыг нэрснийх нь дагуу, шүүхээр шийтгэгдсэн бусад хүний хэргийг өргөдөл гомдлын үндсэн дээр шалгаж шийдвэрлэх, цагаатсан хүн, түүний гэр бүлийнхэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хэлмэгдэгсдийн талаар судалж түүхэн үнэнийг тогтоох, нэр төрийг сэргээх ажилд холбогдох байгууллага, хүмүүсийг өргөн оролцуулж ажиллах;

б) Улс төрийн хэрэгт хилс шийтгэгдэгсдийг цагаатгах журамд зарим нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлэх.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРИГ

1990 оны 12 дугаар

Дугаар 58

Улаанбаатар

сарын 25-ны өдөр

хот

Ю. МАРИНАГ ШУДАРГА ЖУРАМ МЕДАЛИАР  
ШАГНАХ ТУХАЙ

Улаанбаатар хотын хүнсний захын дэргэдэх нурсан бай-  
шингийн хананд дарагдсан Одсүрэнгийн амь аварч иргэнийхээ  
үүргийг нэр төртэй биелүүснийг үнэлж, Найрамдлын районы  
ОСГ-ны III хорооны иргэн Юзефиин Марилаг Шударга жу-  
рам медалиар шагнастай.

Бүгд Найрамдах Монгол Ард  
Улсын Ерөнхийлөгч

П. ОЧИРБАТ

МОНГОЛЫН ПАРЛАМЕНТЫН БҮЛГЭМИЙН  
ДАРГЫН АЖЛЫН АЙЛЧЛАЛ

Монголын Парламентын Бүлгэмийн Гүйцэтгэх Хорооны  
дарга С. Зориг энэ оны 1 дүгээр сарын 9—14-нд ЗСБНХУ-ын  
Дээд Зөвлөлийн урилгаар ЗХУ-д ажлын айлчлал хийв.

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Холбооны Зөвлөлийн дарга,  
Зөвлөлтийн Парламентын Бүлгэмийн дарга И. Д. Лантев,  
ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн дарга Б. Н. Ельцин нар  
С. Зоригийг хүлээн авч уулзав. Мөн С. Зориг ЗСБНХУ-ын  
Дээд Зөвлөлийн Эдийн засгийн шинэчлэлтийн байнгын хороо,  
талаад хэргийн байнгын хороо, Гадаад явдлын яамны хариуц-  
лагатай ажилтнуудтай уулзаж, хоёр парламентын хооронд хам-  
тын ажлалагаа хөгжүүлэх асуудлаар санаа солилцов.



---

Эмхтгэсэн Б. Одожила  
Техник редактор Б. Оюундагэр  
Хянагч С. Итгэл

Зэл № 180.

Үйлдвэрт шилжүүлсэн 1991 оны 1-р сарын 31-нд.  
Өрнөлд 1991 оны 2-р сарын 21-нд. Хэвлэлд  
1991 оны 3-р сарын 1-нд. Цаасны хэмжээ  
60х90/16. Хэвлэлийн хуудас 6,5. Хэвлэсэн тоо  
10000 ширхэг. Үнэ 4 төгрөг.

**Засгийн газрын хэвлэх үйлдвэр**

